

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС АГЕНТЛАГ, СУМДЫН
2017 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2017.10.04

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид тайланд сарт 1 удаа хуралдаж 9 асуудлыг хэлэлцэж, 11 тогтоол баталлаа. Үүнд:

Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төр, төсвийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл үүсэхээс сэргийлэх, иргэдэд шударга ёсны зан үйлийг зөв төлөвшүүлэх зорилгоор “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”, аймгийн нутаг дэвсгэрээс 2017 онд ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум тус бүрээр агнуурын бүс нутгийн хамт баталсан.

-Мандал сумын 3 дугаар багт хүн амын тооны өсөлтөөс шалтгаалан сургуулийн насны хүүхдийн тоо нэмэгдэж, 1,3 дугаар сургуулийн бүлэг дүүргэлт тогтоосон хэмжээнээс хэтэрч, 1 багшид ногдох хүүхдийн тоо ихэсч байгааг харгалзан хүүхдийн сурч хөгжих таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, бусад сургуулиудын ачааллыг бууруулах, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Мандал сумын 3 дугаар багт төрийн өмчийн ерөнхий боловсролын бүрэн дунд 4 дүгээр сургуулийг шинээр байгуулах, аймгийн нутаг дэвсгэр дэх байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, хуваарилах, хөрөнгө оруулалт татах замаар орон нутгийн эдийн засгийн чадавхийг сайжруулах, орон нутгийг хөгжүүлэх санд хуримтлал үүсгэх, шинээр ажлын байр бий болгох зорилго бүхий орон нутгийн өмчийн оролцоотой хамтарсан компани байгуулах тухай аймгийн Засаг даргын санал болон “Сэлэнгэ хаш эрдэнэ”, “Хөх бүрдний эх” ХХК-уудын хүсэлтийг тус тус хэлэлцээд Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын болон байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулах үүрэг бүхий “Сэлэнгэ хаш баялаг” ХХК, “Сэлэнгэ ресурс” ХХК-уудыг тус тус хамтран байгуулахаар тогтлоо.

Мөн үндсэн хөрөнгө актлах тухай асуудлыг хэлэлцээд олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид албан ажилд ашиглах боломжгүй, ашиглалтгүй байгаа Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ, Сүхбаатар хотын тохижилт үйлчилгээний газар, аймгийн Цагдаагийн газрын тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмж, аймгийн Цагдаагийн газрын тусгай зориулалтын үндсэн хөрөнгө, аймгийн Цагдаагийн газрын авто тээврийн хэрэгсэл, аймгийн Цагдаагийн газрын барилга байгууламж зэрэг үндсэн хөрөнгүүдийг тус тус актлах тухай болон үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах тухай асуудлыг хэлэлцээд олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид албан ажилд ашиглах боломжгүй, ашиглалтгүй байгаа Боловсрол, соёл, урлагийн газар, аймгийн Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч дуудлага худалдааны доод үнийг баталж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа. Үүнд: Алтан гадас одонгоор 17, Хөдөлмөрийн хүндэт медалиар 15 хүнийг, аймгийн Биеийн тамир, спортын газрын дасгалжуулагч Данзангийн Эрдэнэбатыг “Монгол Улсын Гавьяат дасгалжуулагч” цолоор шагнуулахаар уламжлахаар шийдвэрлэлээ.

Мандал суманд үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны “Хайрын нөхөрлөл” сүмийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар сунгалаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг санан дурсах, тэдний дурсгалыг хүндэтгэн мөнхжүүлэх 80 дахь жилийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд "Улс төрийн хэлмэгдүүлэлтийн үр дагавар, сургамж" уулзалт, хэлэлцүүлгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын "Иргэний танхим"-д 9-р сарын 4-ний өдөр зохион байгуулж, уулзалт, хэлэлцүүлэгт хэлмэгдэгсдийн үр хүүхдүүд, Сүхбаатар сумын зарим иргэд, түүхч, судлаачид, аймгийн Тагнуулын газар, Прокурор, Шүүхийн төлөөлөл нийт 40 орчим хүмүүс оролцож, оролцогчдоос гарсан саналыг Цагаатгах ажлыг удирдах зохион байгуулах Улсын комисст хүргүүллээ.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын өргөтгөсөн хуралдааныг 8-р сарын 31-ний өдөр зохион байгуулж, сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс албадын дарга нарт оролцож, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, өвс хадлан тэжээл бэлтгэх, сургууль цэцэрлэгийн засвар үйлчилгээ, албан байгууллага, айл өрхийн халаалт, засварын ажлыг яаравчлах талаар болон цаг үеийн бусад ажил арга хэмжээний талаар холбогдох газруудад үүрэг чиглэл өглөө.

Аймгийн хэмжээнд ургац хураалтын мэдээгээр энэ сарын 20-ны байдлаар улаанбуудай 10,6 цн буюу 140,4 мянган тн, тэжээлийн ургамал 11,0 цн буюу 11,2 мянган тн, тосны ургамал 5,2 цн буюу 12,9 мянган тн, төмс 122,5 цн буюу 29,8 мянган тн, хүнсний ногоо 2363,5 га-аас 129,1 цн буюу 30,5 мянган тн ургац хураан авсан мэдээтэй байна.

"Намрын ногоон өдрүүд-2017" нэгдсэн арга хэмжээний хүрээнд шинэ ургацын төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний, "Эрүүл хүнс-2017" хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг энэ сарын 18-25-ны өдрүүдэд "Мишээ ЭКСПО" төвд зохион байгуулсан. Энэхүү үзэсгэлэн худалдаанд Шаамар, Сүхбаатар, Зүүнбүрэн, Мандал, Алтанбулаг, Баянгол, Цагааннуур, Жавхлант, Орхон, Хушаат сумдын 70 гаруй ногоочин, 6 хүнс үйлдвэрлэгч оролцож, 1500 ширхэг хмелийн талх, 300 ширхэг "Хатаасан цоохор майлз" хоол амтлагч, 1500 тн төмс, 2500 тн хүнсний ногоо, 8000 ширхэг даршилсан ногоо, 1,5 тн зөгийн бал борлуулж, 1 тэрбум 100 сая төгрөгний борлуулалт хийж, 7 хоногийн турш нийслэлийн хүн амыг экологийн цэвэр төмс, хүнсний ногоо, хүнсний бүтээгдэхүүнээр хангасан. Уг үзэсгэлэн худалдаанаас "Зохион байгуулалт сайтай оролцсон аймаг"-аар, "Зохион байгуулалт сайтай сум"-аар Зүүнбүрэн сум, "Шилдэг ногоочин"-оор Шаамар сумын ногоочин Б.Оюунбилэг, С.Оюунтүлхүүр, Жавхлант сумын ногоочин Д.Сосорбарам, Зүүнбүрэн сумын ногоочин А.Оюунчимэг, "Шилдэг жимс жимсгэнэ, мод бут үржүүлэгч"-ээр Шаамар сумын Д.Баттөр, "Шилдэг хоршоо"-оор Мандал сумын "Зүүнхараа" хоршоо, "Эрүүл хүнс-2016" хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаанаас "Шилдэг орон нутгийн хүнсний бүтээгдэхүүн"-ээр Мандал сумын "Түнхий сүү" хоршоо шалгарч өргөмжлөл цомоор шагнагдсан байна.

Аймгийн хэмжээнд 17 сумын 54 багт 9,5 мянган малчин болон мал бүхий өрхөд 1,6 сая толгой мал өвөлжинө. Одоогийн байдлаар малчид орон нутагтаа отор нүүдэл хийж, мал сүрэгтээ тарга тэвээрэг авахуулах ажлыг хийж байна. Энэ жил малчдын хэрэгцээнд 121,1 мянган тн өвс, 24,2 мянган тн хүчит тэжээл, 4,8 тн эрдэс тэжээл бэлтгэн авах шаардлагатай байгаа.

Жил бүр манай аймаг 150,0 мянган тн байгалийн хадлан бэлтгэдэг боловч энэ жил хуурайшилт ихтэй, гандуу байгаагаас дээрхи хэмжээний байгалийн хадлан бэлтгэх нөөц боломж бага байна. Сумдаар нь авч үзэхэд Орхонтуул, Орхон, Сант, Баруунбүрэн, Сайхан, Мандал, Баянгол зэрэг сумууд хадлангийн гарц муутайгаас шаардлагатай хэмжээний өвс бэлтгэх боломж багатай харин Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар, Алтанбулаг, Ерөө, Хүдэр зэрэг сумууд тодорхой хэмжээний хадлан авах боломжтой байгаа бөгөөд дээрхи хадлангийн нөөц багатай сумдад 45,0 мянган тн өвс дутагдах төлөвтэй байна.

Монгол Улсын ЗГХЭГ-ын орон нутгийн удирдлага зохицуулалтын газраас санаачлан НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Монгол улсад төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгонд “Хот тосгоны тулгамдсан асуудал” хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Монгол Улсын хэмжээний 15 тосгоны захирагч нар, ЗГХЭГ-ын удирдлагууд, харъяа яамдын төлөөллүүд оролцож, хот тосгодын өнөөгийн тулгамдаж байгаа асуудал болон цаашид анхаарах чиглэл дээр хамтран ярилцаж, санал бодлоо солилцлоо.

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын харъяа Мандал сум дахь Онцгой байдлын хэлтэс нь шинэ байртай болж нээлтийн үеэр 6, 7-р саруудад гарсан ой, хээрийн түймрийн голомтонд хамт олноо хошуучлан олон хоног ажилласан зарим алба хаагчдыг Онцгой байдлын ерөнхий газар, аймаг орон нутаг болон бусад байгууллагын шагналаар шагнаж урамшуулав.

Аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг, спортын цогцолбор “ДӨЛ-2017” тэмцээн 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Хүүхэд багачуудад эх оронч сэтгэлгээг төлөвшүүлж, бие бялдар, сэтгэл санааны хатуужлыг суулган, авхаалж самбаа хурд хүч, оюун ухааныг нь тэлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “ДӨЛ” тэмцээнийг зохион байгуулдаг. Тэмцээнд Сүхбаатар, Сайхан, Мандал, Баянгол, Хүдэр, Жавхлант, Цагааннуур сумдын нийт 12 багийн тамирчид 12 төрлийн тэмцээн уралдаанаар 2 өдрийн турш өрсөлдсөнөөс Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн “Соёмбо” тасаг тэргүүн байрт шалгарч, улсын аваргад оролцох эрхээ авч, удаах байруудад Сүхбаатар сумын 5 дугаар сургууль, Мандал сумын 3 дугаар сургуулийн багууд шалгарав.

Сэлэнгэ аймагт Биеийн тамир спортын байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 70 жилийн ойн хүрээнд аймгийн Засаг даргын ивээл дор ахмад багш, Алтан гадас одонт, Ардын Боловсролын Тэргүүний Ажилтан, Биеийн Тамирын Тэргүүний Ажилтан Н.Аюу агсны нэрэмжит “Сэлэнгэ цом” өсвөр үеийн кросс гүйлтийн Улсын аварга шалгаруулах тэмцээн 09-р сарын 23-ны өдөр Сүхбаатар суманд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Өсвөр насны хүүхэд багачуудын чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлж, бие бялдрыг чийрэгжүүлж, биеийн тамир спортын төрлийг хөгжүүлж, спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэхэд энэхүү тэмцээний ач холбогдол байж, тэмцээнд Төв, Булган, Ховд, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын дүүргүүдийн 14 багийн 190 гаруй тамирчид 8-9, 10-11, 12-13, 14-15, 16-17 насны ангилалд 1000, 1200, 1500, 3000, 5000 метрийн зайд хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн. Багийн дүнгээр : Тэргүүн байрт Очирдарь дасгалжуулагчтай Төв аймаг, дэд байрт Ч.Мөнхбаатар дасгалжуулагчтай Сэлэнгэ аймаг Гутгаар байрт Х.Батбилэг дасгалжуулагчтай Дархан-Уул аймгийн баг тамирчид шалгарлаа.

Онцгой байдлын талаар:

“Эрчим хүч үйлдвэрлэгч, түгээгч байгууллага”-уудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах гүйцэтгэлийн шалгалтын удирдамж”-ийн шалгалтын хүрээнд “Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх Сүлжээ” ХХК-ний Сэлэнгэ салбар, ХТП-1 Корпус, Гурван мэргэд зах ХТП-3, ХТП-6, ХТП-15 Цахилгаан эрчим хүчээр хангах дэд станц, Сайхан сумын 1, 2-р баг, Номгон 3-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “ДСЦТС” ХК Хөтөл салбарын байр болон ТП-8, КТП-5, Мандал сумын “ДСЦТШС” ХХК-ний Зүүнхараа түгээх салбар, ЦДҮСТӨХК-ний 115/35/6 кВт-ын Зүүнхараа дамжуулах дэд станц зэрэг нийт 12 объектод гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 45 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 6, мэдэгдэл 6-г үйлдэж байгууллагын удирдлагуудад өгч ажиллаа.

2017 оны 09 дүгээр сард 4 удаагийн объектын гал түймэр гарснаас 4 гал түймэр мэдээллээр ирж 4 гал дээр гал түймэр унтраах, аврах анги ажиллаж унтраасан. Гарсан 1 гал түймрийн хэргийг Цагдаагийн байгууллагатай хамтран шалгаж, гал

түймэр гарсан тухай акт 2 үйлдэж шийдвэрлэсэн, 1 зөрчилд зөрчлийн тэмдэглэл үйлдсэн байна.

Гал түймрийн шалтгаан нөхцлийг судалж үзвэл цахилгааны угсаралтын буруугаас 2, машин техникийн гэмтлээс 2 удаа тохиолдсон байна.

Гал түймрийн нөхцөл байдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:

д/д	Гал түймрийн төрөл	2016 оны 9 дүгээр сар	2017 оны 9 дүгээр сар	Өссөн, буурсан
1	Объектын	-	4	4-өөр өссөн

Орон нутгийн ус, цаг уур, орчны шинжилгээний албанаас цаг агаарын нарийвчилсан мэдээллийг авч орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэнээс гадна болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг орон нутгийн кабелийн телевизээр-2, сонинд-1 удаа мэдээ явуулсан.

Сэлэнгэ Есөн-эрдэнэ ХХК-ний гүйцэтгэсэн Цагааннуур сумын төвийн 1.3 км хатуу хучилттай замыг байнгын ашиглалтанд хүлээн авах улсын комисст ажиллан үүрэг чиглэл өгсөн.

Гэр орон сууцны галын аюулгүй байдлыг хангуулах зорилгоор Сайхан сумын гэр хорооллын 150 айл өрхүүдээр гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмжийг 200 ширхэгийг тараасан.

Булган аймагт зохион байгуулагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллага, Онцгой байдлын Ерөнхий газраас хамтран зохион байгуулсан “Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх нь болон эрсдэлийн үнэлгээ” сэдэвт 2 өдрийн сургалтанд Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, АССУСАХМ, аймгийн барилга хот байгуулалтын газрын 4 мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй хамрагдсан.

ОБГ-ын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн А/26 тоот тушаалын дагуу Гал түймэр унтраах аврах 19, 36, 40, 61 дүгээр анги, Хилийн цэргийн 0243-р ангийн шуурхай бүлгийн алба хаагчдад “Уснаас эрэн хайх аврах ажиллагаа”-ны дадлага сургалтыг 2017 оны 9 дүгээр сарын 04-09-ний хооронд зохион байгуулсан. Уг сургалтаар “Уснаас эрэн хайх ажиллагааны журам”, “Аврагч-усчин, шумбагчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”, “Шумбагчийн дохио”, “Завь сэлүүрдэх болон моторт завь барих арга техник”, “Усанд осолдсон хүнд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж”, “Амилуулах суурь тусламж”, “Усанд сэлэх арга техник”, “Гүний шумбагчийн өмсгөл, аппарат түүний тактик техникийн өгөгдэхүүн, ашиглах горим”, “Завьтай аврах ажиллагааг зохион байгуулах”, “Урсгал усанд аврах ажиллагаа, урсгал усанд сэлэх, шумбах арга техник”, “Үерт автсан нэрвэгдэгчид болон эд хөрөнгийг завиар зөөвөрлөх аюулгүй ажиллагаа” сэдвээр нийт 43 цагийн онол, дадлагын сургалтыг зохион байгуулан явуулж сургалтанд анх удаа болон шинээр хамрагдсан алба хаагчдад гэрчилгээ олгосон.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон “Тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийх ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд тус хэлтсийн баталгаажуулалтын шинжээч ажиллаж, холбогдох стандартын шаардлагын дагуу Сүхбаатар сумын 3 багийн 10 худалдаа үйлчилгээний газарт хяналт, шалгалтын

ажлыг хийсэн. Аймгийн Засаг даргаас ирүүлсэн чиглэлийн дагуу намрын ургац хураалтанд ашиглагдах авто пүү баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэхэд анхаарч 33 авто жинг баталгаажуулалтанд хамруулахаас 30 авто жинг ээлжит баталгаажуулалтанд хамруулаад байна.

Мэдээллийн ил тод, нэгдмэл байдлыг ханган Стандарт, хэмжил зүйн төрийн бодлого, хэлтсээс зохион байгуулж, буй арга хэмжээний талаарх шинэлэг мэдээ, мэдээллийг байгууллагын face хуудаст байршуулан, мэдээлж, 2017 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу Хэмжил зүйн лабораторийн Чанарын гарын авлагын 4-р бүлэгт дотоод аудит хийж, зөвлөмж, өгч ажиллав.

Стандарт, хэмжил зүйн газраас энэ сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулсан баталгаажуулалтын шинжээч нарын сургалт, аттестатчилалд тус хэлтсийн баталгаажуулалтын шинжээчид оролцсон.

Мандал, Ерөө, Алтанбулаг, Баянгол, Сүхбаатар, Зүүнбүрэн сум, Бугант тосгонд ажиллаж 8 хүнсний дэлгүүр, 6 минимаркет, 1 хүнсний мухлаг, 4 зоогийн газар, 1 кафе, 1 амралтын газар, 1 караоке баар нийт 22 үйлчилгээний газарт холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ олгож, Сүхбаатар, Шаамар, Орхонтуул сумдын 7 аж ахуйн нэгжийн 5 нэрийн 13 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж өгсөн. Мөн Ерөө сумын “Моностойн нуруу” ХХК-ийн үйлдвэрлэж буй “Ноёт” сортын арвайн гурилны хаяг шошгыг холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлүүлж, МХЕГ-ын Нэгдсэн лавлагаа лабораторит сорилт шинжилгээнд хамруулж, сорилтын дүнг үндэслэж бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ олгов.

Сүхбаатар сумын “Шилмэл Эсгий” ХХК-ийн үйлдвэрлэж буй эсгий гутлыг АНУ-д экспортлож байгаатай холбогдуулж, 69 кг эсгий гутланд экспортын гэрчилгээ олголоо.

Мандал, Хүдэр суманд шинээр шатахуун түгээх станц ашиглалтанд орсон тул дуудлагын дагуу шатахуун түгээгүүрийн 6 шингэн хэмжигчид, 5 айл өрх, аж ахуйн нэгжийн усны тоолуурыг шалган баталгаажуулснаас гадна 2017 оны гэрээний дагуу “ДСЦТС” ХК-ний лабораторитой хамтран Мандал, Сайхан суманд цахилгааны тоолуур баталгаажуулалтанд хамруулах ажлыг зохион байгуулж, 582 ш цахилгаан тоолуур баталгаажуулалтанд хамрууллаа.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Цаг үе, ажлын шаардлагаар Алтанбулаг, Шаамар сумын Дулаанхаан тосгонд хэлтсийн групп шалгалт явуулж, илэрсэн зөрчил дутагдалд хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс, Автотээврийн төв, Албан журмын даатгагчдын холбоо, Ард, Бодь, Миг, Монгол, Монре, Номин, Практикал, Соёмбо, Тэнгэр даатгалын компаниудтай хамтран 2017 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Сүхбаатар сумын Олон улсын худалдааны төвд “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгууллаа. Даатгалын компаниуд 9 харилцагчид даатгалын үйлчилгээ үзүүлж, 85 хүнд зөвлөгөө өгсөн. Авто тээврийн төвөөр шилжилт хөдөлгөөн 9, хяналтын үзлэг 10, зөвлөгөө 7 иргэнд үзүүлсэн. Татварын хэлтсээр 21 иргэн үйлчлүүлж, эзэмшигчийн өөрчлөлт, хөдөлгүүрийн багтаамжийн өөрчлөлт, шинээр гэрчилгээ олгож, АТӨЯХАТ, агаарын бохирдлын төлбөр болох 553.7 мянган төгрөгийг төвлөрүүллээ.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	14,679,860.6	14,420,296.4	98.2
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	8,857,175.1	7,888,234.3	89.1
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	51,993,850.2	45,234,044.7	87.0
	- Аймгийн төсвийн зарлагын дүн	12,643,293.4	10,206,981.5	80.7
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	420,701.6	348,097.8	82.7
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	908,578.5	163,203.2	18.0

	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,626,976.1	763,355.3	46.9
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	1,613,648.0	1,613,648.0	100.0
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	2,500,000.0	2,500,000.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	29,126,285.1	29,126,285.1	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	15,243,522.5	15,243,522.5	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	7,479,871.8	7,479,871.8	100.0
	- Соёлын байгууллага	1,948,038.9	1,948,038.9	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	612,217.0	612,217.0	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	3,489,553.6	3,489,553.6	100.0
	- ГХБХБГазар	150,812.7	150,812.7	100.0
	- ГБХЗХГазар	202,268.6	202,268.6	100.0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	29,126,285.1	29,126,285.1	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	15,243,522.5	15,243,522.5	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	7,479,871.8	7,479,871.8	100.0
	- Соёлын байгууллага	1,948,038.9	1,948,038.9	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	612,217.0	612,217.0	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	3,489,553.6	3,489,553.6	100.0
	- ГХБХБГазар	150,812.7	150,812.7	100.0
	- ГБХЗХГазар	202,268.6	202,268.6	100.0
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	2,304,125.1	2,311,125.1	100.3
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1327439.3	1239295.2	93.4
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	562,259.1	562,259.1	100.0
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	374,100.3	374,100.3	100.0
11	Тусгай сангуудын зарлага	1,081,740.9	276,210.3	25.5

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2017 VIII сар	2017 IX сар	2017-IX 2017-VIII /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 250	1 250	
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 100	
	Нарийн боов /кг/	2 200	2 500	+300
	Будаа /кг/	2 500	2 300	-200
	Элсэн чихэр /кг/	2 200	2 300	+100
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 000	6 500	+500
	Үхрийн мах /кг/	7 000	7 000	
	Адууны мах /кг/	6 000	6 000	
	Ямааны мах /кг/	5 000	5 000	
	Дотор мах, цувдай /цусгүй/	3 000	3 000	

	Хиам /чанасан, кг/	10 000	11 000	+1 000
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	600	700	+100
	Сүү / савласан, л/	2 500	2 600	+100
	Тараг /задгай, л/	1 200	1 000	-200
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	13 000	
	Айраг /л/	3 500	3 500	
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 000	4 500	+500
	Өндөг /ш/	320	320	
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	
	Өөхөн тос /кг/	1 800	1 800	
	Шар тос /кг/	10 000	11 000	+1 000
	Масло /задгай, кг/	4 000	4 500	+500
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	2 500	1 200	-1 300
	Лууван /кг/	1 500	1 500	
	Манжин /кг/	1 500	1 500	
	Байцаа /кг/	1 500	1 500	
	Сонгино /кг/	1 500	1 500	
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 300	4 000	+700
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630gr/	2 600	2 800	+200
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 480	1 480	
	Бензин А - 92	1 630	1 620	
	Дизелийн түлш	1 720	1 720	

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.Хууль эрх зүй, цагдаа, улсын бүртгэлийн талаар:

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэг, хоёрдугаар шатны уулзалт хэлэлцүүлгийг багийн иргэдийн дунд, гуравдугаар шатны уулзалт хэлэлцүүлгийг УИХ-ын ажлын хэсгийн баталсан хуваарийн дагуу бүсчилсэн хэлбэрээр хийж, 8 дугаар сарын 15-ны өдөр Мандал суманд, 08 дугаар сарын 20-ны өдөр Сүхбаатар суманд, 08 дугаар сарын 22-ны өдөр Сайхан суманд тус тус зохион байгуулж, 17 сум 3 тосгоны нийт 5325 иргэн оролцож, 7195 саналын хуудсыг аймгийн хэмжээнд нэгтгэн авч Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлсэн.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-үүдийг шинээр боловсруулан аймгийн Иргэдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүллээ. Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга буюу нотариатын үүрэг гүйцэтгэгч нарт зориулсан “Нотариатын үйлдэл хийх аргачлал” сэдэвт сургалтыг 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, сургалтын хөтөлбөрийн дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон нутаг дахь үйл ажиллагаа, Өрсөлдөөний тухай болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн ойлголт, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хөтөлбөрийн хэрэгжилт, Зөрчлийн тухай хуулийн ойлголт, анхаарах асуудал, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хангах ажилд анхаарах асуудал, Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт, анхаарах асуудал, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт өгөх үүрэг даалгавар, анхаарах асуудлууд зэрэг сэдвүүдээр хийсэн. Сургалтанд Монголын Нотариатчдын танхимын удирдах зөвлөлийн гишүүн, нотариатч, сургагч багш Ч.Эрдэнэбаяр оролцсон.

Аймгийн хэмжээнд 2017 оны 08 дугаар сард 452 холбогдогчтой, 905.6 сая төгрөгийн хохиролтой, 493 гэмт хэрэг бүртгэгдэж, 11 хэргээр буюу 2,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн гаралт Сүхбаатар сум болон 1, 6, 7-р баг, Алтанбулаг, Ерөө, Бугант, Зүүнбүрэн, Хушаат, Мандал, Баянгол, Орхон сумдад 3.0-66.7 хувиар, Хүдэр суманд 2.8 дахин, Сүхбаатар сумын 3, 4, 5, 8-р баг, Шаамар, Жавхлант, Цагааннуур, Түшиг, Сант, Орхонтуул, Баруунбүрэн сумдад 10-60 хувиар тус тус буурч, Сүхбаатар сумын 2-р баг, Дулаанхаан тосгонд өнгөрсөн оны мөн үетэй адил түвшинд байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээнд 2017 оны 09 дүгээр сард 222 төрөлт, 49 гэрлэлт, 6 гэрлэлт цуцлалт, 58 нас баралт бүртгэгдэж, 1122 иргэнд цахим үнэмлэх, 59 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэх 5347 ширхэг олгож, аймаг, хотруу шилжин явсан 179, шилжин ирсэн 168, сум дүүрэгт шилжин ирсэн 102, сум дүүрэгт шилжин явсан 103, баг хооронд шилжин ирсэн 307, баг хооронд шилжин явсан 287 шилжилт хөдөлгөөн тус тус бүртгэгдээд байна. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлд 570 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 925 бүртгэл бүртгэгдэж, улсын тэмдэгтийн хураамжийн 267,580 төгрөг, үйлчилгээний хураамжийн 12,045,227 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварт 20,449,000 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

2.Архивын талаар

“Баримт бичгийн стандарт” сургалтыг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт зохион байгууж, газар, хэлтэс, албад, сумдын төр төсвийн байгууллагуудын архив, бичиг хэрэг хариуцсан ажилтнуудын төрийн болон салбарын шагналд тодорхойлсон судалгаа, материалыг Архивын ерөнхий газарт хүргүүлсэн.

Албан байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Өвөрхангай аймгийн Архивын тасагт тус аймгийн Төгрөг сумын иргэн Лувсандорж овогтой Болормаад холбогдох цалингийн лавлагаа, тушаалын хуулбар, Улаанбаатар төмөр замын барилга ашиглалт үйлчилгээний 1 дүгээр ангийн үйлдвэрчний эвлэлийн хороонд иргэн Х.Бямбасүрэнтэй холбогдох архивын лавлагаа, Орхон аймгийн эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэст иргэн Э.Сувд-Эрдэнэ, Ч.Баасанжав, Ө.Алтанцэцэг нарт холбогдох баримтуудыг хүргүүллээ.

2017 оны нягтлан шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу Материал техник, хангамжийн удирдах газрын хөмрөгийн 1974-1990 оны 108 ХН, Зүүнхараа дахь Авто тээврийн 42 дугаар баазын хөмрөгийн 1975-1990 оны 95 ХН, Зүүнхараа хотын Хүнсний үйлдвэрийн хөмрөгийн 1954-1998 оны 166 ХН-д нягтлан шалгалтын ажлыг хийж, дансны шинэчилсэн бүртгэл, устгах бичгийн акт болон дансны бүрдлийг хангаж, “Талхун Арал” ХХК-ий гүйцэтгэсэн Баруунбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажлын гүйцэтгэл, АЗЗА ТӨХК-ны гүйцэтгэсэн Нэгдсэн эмнэлгийн зам засвар, Өнөр зам хариуцлагатай компаний гүйцэтгэсэн Хушаат сумын зам засвар, тэмдэг, тэмдэглэгээ, Экструуд констракшин ХХК-ны гүйцэтгэсэн Алтанбулаг сумын Гаалийн шалган нэвтрүүлэх байрны нийтийн бие засах өрөөний тохижилт, Оюут гол ХХК-ны Сант сумын цэцэрлэгийн барилгын дотор халаалтын зураг төслийн баримт бичгийг хүлээн авч бүртгэл акт үйлдэн хөмрөгт байрлуулсан.

Иргэд албан байгууллагын хүсэлтийн дагуу цахим болон цаасан суурьтай баримтаас архивын хуулбар 159, цалингийн лавлагаа, магадлагаа, тодорхойлолт 27-г гаргаж үйлчилсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

Аймгийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт ажиллаж байгаа багш, удирдах ажилтнуудад “Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй”, “Багшийн ёс зүй, харилцаа” сургалтыг 2017 оны 08 дугаар сарын 24, 25-ны

өдрүүдэд Сүхбаатар сумын 1, 3, 4 дүгээр сургуулиуд дээр зохион байгуулж сургалт семинарт ахлах ангид хичээл заах багш судлагдахуун бүрээр нийтдээ 582, бага ангийн багш 80, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч 70 хүн бүгд 732 хүн хамрагдсан. Мөн 2017-2018 оны хичээлийн жилд нэгдүгээр анги даан ажиллах багш нарт зориулсан “Бэлтгэл хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт сургалт зохион байгуулж, нийт 70 багш хамрагдаж 2017-2018 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид шинээр элсэн суралцаж буй сурагчдын судалгааг авч нэгтгэн 9 сарын эхний байдлаар 75 бүлэгт 2209 сурагч хичээллэж байна.

Энэ сарын 6, 7-ны өдрүүдэд Жэжүгийн Олон Улсын хүүхэд залуучуудын чуулга уулзалтад оролцох хүсэлтэй сурагчдын сонгон шалгаруулалтыг явуулж, сонгон шалгаруулалтанд 3 сургуулийн 6 сурагч оролцсоноос Сүхбаатар сумын Улсын тэргүүний 4-р сургуулийн 2, Мандал сумын 1-р сургуулийн 1, Сайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1 нийт 4 сурагч шалгарлаа.

Мөн 09 дүгээр сарын 14-15-нд Шаамар сумын сургууль дээр “Эко сургууль”-ийн анхан шатны сургалтыг зохион байгуулж Сүхбаатар сумын 1, 2, 4-р, Хушаат, Шаамар сумын сургуулийн удирдлага, багш, сурагч зэрэг нийт 50 хүн оролцсон.

“Музей ба хөгжил-2017” Монголын музейчдын чуулга уулзалтыг 9-р сарын 8-10-ны өдрүүдэд зохион байгуулсан ба чуулганд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбат, Соёл урлагийн газрын дарга Болд болон холбогдох мэргэжилтнүүд АНУ, ОХУ-ын соёлын өв судлаачид болон Монгол Улсын 38 музейн 380 гаруй музейчид оролцсон. Музейчидын дунд Урлаг спортын наадам зохион байгуулж волейболын тэмцээнд нийт 21 аймгийн 24 багийн тамирчид оролцлоо.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2017 оны 08-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 904 байсан бол 119 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 57 ажлын байранд 45 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 61 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 917 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 09-р сарын байдлаар 28781 иргэнд 7,354,033,086 төгрөгийг олгоод байна. Хушаат, Жавхлант, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумдын 2017 оны хөтөлбөр төслийн хэрэгжилттэй танилцан хяналт шинжилгээ хийж, 2014-2016 онд хийгдсэн төсөл хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийн эргэн төлөлтөнд шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Баянгол сумын Засаг даргын Тамгын газартай хамтран ажлын байрны өдөрлөгийг зохион байгуулж, нийт 200 гаруй иргэдэд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн хуулийг сурталчилан таниулах зөвлөгөө мэдээлэл, Ерөө сум, Бугант тосгоны бичил уурхай өрхийн хүүхдүүдэд “Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгая” сэдэвт сургалт, мэдээллийг өгч ажиллалаа.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт салбар хорооноос Зүүнбүрэн, Цагааннуур, Хушаат, Баянгол сумдын аж ахуйн нэгж байгууллагуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийн хүрээнд хяналт шалгалт хийж ажилласан. Мэргэжил олгох сургалтын хүрээнд Мандал, Алтанбулаг сумдад сантехникч, оёдолчин мэргэжлээр 45 иргэнийг суралцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

3.Эрүүл мэндийн талаар

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд С вирус тоолуулахаар Бона-Вита болон Онкоген лабораторид илгээсэн сорьцын хариуг сумын эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж С вирус илэрсэн иргэдийг эмэн эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

“Улаан бурхан өвчний бэлэн байдал, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний аргачлал”, халдварт саа өвчин гарахаас сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний үндэсний төлөвлөгөө”-г боловсруулахтай холбогдуулан уг баримт бичгийг хэрэгжүүлэх, дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалтын талаар 5 аймгийн бүсчилсэн сургалтыг 08 дугаар сарын 31-нээс 09 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулж Сэлэнгэ, Орхон, Булган, Хөвсгөл, Дархан-Уул аймгийн 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

“Эрүүл оюутан-Эерэг хандлага” аяныг Сүхбаатар, Мандал, Шаамар сумдын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын дунд өрнүүлж аяны хүрээнд оюутан залуучууд бэлгийн замын халдварт өвчин, архи, тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн даатгалын ач холбогдлын талаар ойлголттой болгох талаар тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна. Угийн бичиг хөтлөх санал санаачилгын хүрээнд Хилийн цэргийн 0243 дугаар ангийн сэтгэл зүйч /сургагч багш/ сургалт зохион байгуулсан. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч иргэдийн 9 дүгээр сарын бүртгэл мэдээг Алтанбулаг, Зүүнбүрэн, Сант, Баруунбүрэн, Ерөө, Мандал, Сайхан, Сүхбаатар сумуудаас авч нэгтгэж нийт 8 сумын 12 төвөөр 144 хүүхэд бүртгэгдэж үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхэд байна.

Тайлант сард хүүхдийн тусламжийн утсанд ирсэн 5 дуудлагад хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж, хүүхэд өсвөр үеийг ивээх төвөөс зохион байгуулж буй “Сургагч багш бэлтгэх” сургалтанд 25 сурагчийг хамрууллаа.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг төрийн бус байгууллагын судалгаа, хүүхдийн хөгжил оролцооны байгууллагуудын судалгаа, өдөр өнжүүлэх төвийн судалгааг гаргаж, 8 төрлийн гарын авлага гаргасан.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар

Аймгийн хэмжээнд 2017 оны 09 сарын 20-ны байдлаар 18,4 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 09 дүгээр сарын 20-ны байдлаар өссөн дүнгээр 18,7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 101,3 хувийн биелэлтэй, эрүүл мэндийн даатгалын санд төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл 1,2 тэрбум төгрөг оруулах төлөвлөгөөтөйгээс 1,4 тэрбум төгрөгийг оруулж биелэлт 114 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 15750 тэтгэвэр авагчдад 36335,75 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 4445 хүнд 1477,11 сая төгрөгийг Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, Жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 293 хүнд 728,32 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 391 хүнд 527,78 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг, эмийн сангуудад 3008,37 сая төгрөгийн зардлыг тус тус олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар тайлант сард 284 иргэний материалыг хэлэлцэж, 21 иргэний тэтгэмжийг цуцалж, 64 иргэнд шинээр тогтоож, 199 иргэн актаа сунгуулсан.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуй, байгаль орчин, хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд:

1/Хүнс, хөдөө аж ахуйн талаар

2017 оны 09 дүгээр сарын 1, 6, 17-ны өдрүүдэд зарим сумдын нутгаар 0,0-7,0 мм, 2-4, 7, 9, 14, 15 21-ний өдрүүдэд ихэнх сумдын нутгаар 1,0-36,0 мм бороо орлоо. Бусад хугацаанд бороо ороогүй. 2017 оны09 дүгээр сарын 4, 7, 14, 18, 21-ны өдрүүдэд

салхи ширүүсч 8-13 м/сек, зарим үед түр зуур ширүүсч 14-22 м/сек хүрсэн. Бусад хугацаанд салхи баруун болон баруун хойноосоо 4-9 м/сек байв. Ихэнх хугацаанд шөнөдөө 4-9 градус, өдөртөө 19-24 градус дулаан байв. 7, 9, 10, 15, 21-ний өдрүүдэд ихэнх сумдын нутгаар сэрүүсч шөнөдөө 0-5 градус, өдөртөө 11-16 градус дулаан байлаа.

09 дүгээр сарын II арав хоногийн байдлаар голуудын усны түвшин Сэлэнгэ мөрөн Зүүнбүрэн сум орчмоор усны түвшин 257 см, олон жилийн дунджаас 1 см-ээр бага, Сүхбаатар сум орчмоор усны түвшин 326 см, олон жилийн дунджаас 7 см-ээр бага. Орхон голын усны түвшин Сүхбаатар сумаар 194 см, олон жилийн дунджаас 18 см-ээр бага, Орхон сумаар усны түвшин 174 см, олон жилийн дунджаас 9 см-ээр их. Ерөө голын усны түвшин Ерөө сум орчмоор 269 см, олон жилийн дунджаас 33 см-ээр бага, Дулаанхан сумаар Ерөө голын усны түвшин 247 см, олон жилийн дунджаас 17 см-ээр бага. Хараа голын усны түвшин Баянгол сумаар 160 см, олон жилийн дунджаас 12 см-ээр бага. Хүдэр голын усны түвшин 216 см, олон жилийн дунджаас 2 см-ээр их. Зэлтэр голын усны түвшин 269 см, олон жилийн дунджаас 11 см-ээр их байна.

Бэлчээрийн болон таримал ургамлын хөнөөлт хортон шавьж, царцаа, мэрэгчдийн ажиглалтаар 3-р арав хоногт ихэнх сумдын нутгаар бараан далавчит, тонолжит, барабины таршаа ажиглагдсан.бөгөөд 1м² хүрээнд дунджаар 1-6 тоологдсон. Таримал ургамалд Зүүнбүрэн суманд бараан далавчит, гессений ялаа дунджаар 6 ажиглагдсан байна. Бусад сумдын нутгаар нисэгч болон хөнөөлт хортон шавьж ажиглагдаагүй.

Хушаат сумын үржүүлж буй Казазийн цагаан толгойт үүлдрийн үхрийн ашиг шимийг сайжруулахаар “Mercy corps “олон улсын төслийн байгууллагатай хамтран “Даван туулах дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөрийг хэрэгжүүлж төслийн нээлт энэ сарын 22-ны өдөр Хушаат суманд зохион байгуулагдсан.

Хүнсний аюулгүй байдлыг хангах үүднээс 5,9 тн мах, махан бүтээгдэхүүний 72 дээж, 3,6 тн сүү, сүүн бүтээгдэхүүний 145 дээж, 1577 өндөгний 39 дээж, 302 ш арьс ширний 31 дээж, 0.4 тн ноос, ноолуурын 13 дээжинд МЭАЦ-ийн магадлан шинжилгээ хийж МЭАЦ-ийн магадлан шинжилгээг хийж баталгаажуулалж гэрчилгээ олгосон.

Сүхбаатар, Мандал, Орхонтуул, Зүүнбүрэн, Орхон зэрэг сумдаас ирсэн өвчилсөн, хорогдсон мал, амьтны 27 эмгэгт дээж, мөн Орхонтуул, Баянгол сумын сургууль цэцэрлэгт нийлүүлдэг сүүний үхрийн 35 цусанд лейкоз, бруцеллөз, сүрьеэ өвчний үүсгэгч илрүүлэх ЭЛИЗА урвал, Зүүнбүрэн сум Шимт бүрэнгийн 12 буханд стандарт арга зүйн дагуу оношлогоо шинжилгээг хийж, УМЭАЦТЛ-иор баталгаажуулан хариуг маягтын дагуу гаргуулан авч холбогдох мал эмнэлгийн нэгж болон иргэдэд өгсөн бөгөөд халдварт өвчний үүсгэгч ирлээгүй.

Архангай аймгийн Эрдэнэбулган суманд зохион байгуулагдсан “Төвийн бүсийн Онол үйлдвэрлэлийн бага хурал” -д 17 сумын 26 эмч, мэргэжилтнүүд, “Оношлох эрдэм- дэвшилт арга технологи 2017 он” онол үйлдвэрлэлийн бага хуралд 2 эмч, Шүлхийн эмнэл зүйн, лабораторийн оношлогоо, дээж сонголт, тээвэрлэлт, тэмцэх арга хэмжээ, халдваргүйжүүлэлтийн цогц, систем бүрдүүлэх сургалтанд 1 эмч, 17 сумын ХААТ-ын Хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнүүд хувийн МЭҮН-үүд “Зөгийн аж ахуйд зонхилон тохиолддог зөгийн өвчин, бүртгэл, мэдээллийн хөтлөлт” сургалтанд 1 хоног тус тус хамрагдсан.

2.Байгаль орчны талаар:

Түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг болон түймрийн хор уршгийн тухай баримтат кино 4 удаа гаргасан. Мөн сумын болон сум дундын Ойн анги, байгаль хамгаалагчдыг түймрээс урьдчилан сэргийлэх сурталчилгааны материал тарааж ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/373 дугаар захирамж гарч ажлын хэсэг

байгуулагдан усны орлогыг төвлөрүүлэх ажил явагдаж байна. Үүнд Хүдэр, Ерөө, Мандал, Баянгол, Түшиг сумдууд хамрагдаж байгаа. Захирамжийн хугацаа 10-р сарын 10-ныг хүртэл үргэлжилнэ.

Ерөө сумын Могойн гол нэртэй газарт Азийн хөгжлийн сан, аймаг, сумын хамтарсан хөрөнгө оруулалтаар уул уурхайн олборлолтын улмаас эвдрэлд орсон 5 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хийх юм байна. Дээрх 5 га талбайд нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх нөхөрлөлтэй уулзах, тухайн газрын байршил, солбилцлыг нягтлах зорилгоор аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсийн дарга, ГХБХБГазрын мэргэжилтэн, Ерөө сумын БОХУБайцаагчийн хамт газар дээр нь очиж ажилласан.

Ойн хөнөөлт шавжийн хэт олшролтой Баруунбүрэн суманд 8000 га талбайд, Сант суманд 4000 га талбайд хийгдсэн ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлын гүйцэтгэлийг газар дээр нь үзэж танилцлаа. Ерөө сумын ойн сангийн талбайд гүйцэтгэж буй ой зохион байгуулалтын ажлыг хэрхэн гүйцэтгэх талаар ойн мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийг хамруулан гүйцэтгэгч байгууллага болох “Мөнх ногоон жодоо” ХХК-тай хамтран I зөвлөлгөөнзохион байгуулж оролцлоо.

“Шинэ Бадрах” ХХК-ны мэргэжлийн байгууллагын хугацаа дуусаж сунгаж өгөх хүсэлт ирүүлсэнийг хүлээн авч холбогдох материалтай танилцаж дүгнэлт гарган мэргэжлийн байгууллагын эрх сунгах хүсэлтийг БОАЖЯ-нд хүргүүлсэн.“Бугант Минж” ХХК-ны мэргэжлийн байгууллагын хугацаа дуусаж сунгаж өгөх хүсэлт ирүүлсэнийг хүлээн авч холбогдох материалтай танилцаж дүгнэлт гарган мэргэжлийн байгууллагын эрх сунгах хүсэлтийг БОАЖЯ-нд хүргүүлсэн.

Сумын болон сум дундын ойн ангиудыг чадавхижуулах зорилгоор “Ой зохион байгуулалтын хээрийн ажлын” үзүүлэх сургалтыг тус газар нь Ерөө сумын ашиглалтын бүсийн ойн санд ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэж буй “Мөнх ногоон жодоо” ХХК-тай хамтран зохион байгуулсан. Тус сургалтыг онолын болон практик хэлбэрээр явуулсан бөгөөд 50х50 харьцаатай 2 дээж талбай аван таксацын хэмжилт хийн тоон өгөгдөлийг томъёонд оруулан дүнг тооцож ажилласан. Тус сургалтанд нийт 7 хүн оролцсон.

3.Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын талаар:

Аймгийн Засаг даргын захирамжаар Сүхбаатар сумын 3 иргэнд 1854 м2 газрыг үнэ төлбөргүйгээр өмчлүүлж, Алтанбулаг сумын 3-р баг Номтын амны зүүн урд газар өмчлөх хүсэлт гаргасан 51 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авсан. Мөн газар өмчлөх эрхээ тухайн орон нутагт хэрэгжүүлсэн эсэх лавлагааг нийт 63 иргэнд тус тус хүргүүлсэн. Алтанбулаг, Сүхбаатар суманд газар өмчилж авсан нийт 42 иргэний газар өмчлөлийн баримт материалыг бүрдүүлэн Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлж, газар өмчлөх эрхээ бусдад худалдсан 8, өв залгамжлалаар шилжүүлж авсан 2, бэлэглэлийн журмаар 1 иргэнийг газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер программд бүртгэж, нэгж талбарын хувийн хэрэгт баяжилтыг тухай бүр хийж, газрын цахим биржид энэ сарын байдлаар 36 барьцаа, 3 зах зээлийн үнийн мэдээг бүртгэж оруулсан.Ààçàð ýçýì ø èõ ýðõ î ëã õ áí ëî í äãçàð ýçýì ø èõ ýððëéí äýð-èëäýúí èé õóããõàà ñóí äãñàð õõðàé äðããñàí 15 èðäýí èé °ðä äëëëã ø èéäüðëýæ òàðëóáí ýáýäñýí áàéí à.

Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Топмап” ХХК, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын кадасын хэлтсийн мэргэжилтнүүдтэй хамтран энэ сарын 21-25-ны өдрүүдэд сумдын газрын даамлуудад сургалт хийж, сумын хэмжээнд “Лэнд менежер” программыг бүрэн нэвтрүүлээд байна.

Зургаа.Сум орон нутгийн талаар:

Алтанбулаг сум:

2017 оны 9-р сарын 25-ны байдлаар сумын дүнгээр үр тариа хураалт 60 гаруй хувь, төмс, хүнсний ногоо 91 хувь, хадлан бэлтгэл 70 гаруй хувьтай байна. Сум хөгжүүлэх сангийн төслийн сонгон шалгаруулалт явагдаж, 5 иргэний төсөл шалгарч, санхүүжилтээ авахад бэлэн болгосон.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаархи олон нийтийн хэлэлцүүлгийг 2017 оны 08 дугаар сарын 28-нд сумын иргэдийн дунд зохион байгуулж санал хүсэлтийг хүлээн авсан. Сумын хэмжээнд нийт 320 иргэнд саналын хуудас явуулж санал хүсэлтийн хүлээн авч холбогдох газарт тайланг хүргүүлж ажилласан.

Сумын хэмжээнд байгаль орчны хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар эргүүл шалгалтыг нийт 10 удаа холбогдох газрууд хамтран зохион байгуулснаас гадна сумын Цагдаагийн хэсгээс ойн сан гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, иргэдэд Ааéääëü î ð-í û гэмт хэргийн талаар сургалт явууллаа.

2017-2018 оны хичээлийн жилд сумын хэмжээнд цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдүүд тоо 330, сургууль цэцэрлэгийн өвөлжилтийн бэлтгэл бүрэн хангагдсан. СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөрийг өдрийн дэглэмийн дагуу хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, “Хүн болох багаасаа” сумын дэд хөтөлбөрийн дагуу ажлын төлөвлөгөө боловсруулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Цэцэрлэгийн багш ажилчид болон эцэг эх, хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Алтан намар” өдөрлөгийг энэ сарын 8-ны өдөр бэлтгэл бүлгийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран амжилттай зохион байгуулаад байна.

Сумын ЕБС-ийн шинэ хичээлийн жилийн нээлтэд УИХ-ын гишүүн Н.Оюундарь оролцож 1-р ангид элсэн орж байгаа сурагчдад гарын бэлэг гардуулсан ба МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Эх хэлний өдөр” болгон тэмдэглэж, сурагчдын анги насанд нь тохируулан хичээллэсэн. “Ардын аман зохиолоосоо суралцан эх хэлээ дээдэлъе” төслийн нээлтийг хийж, төслийн хүрээнд орон нутгийнхаа түүх соёлын дурсгалт газартай танилцах явган аялалд 1-5 дугаар ангийн 15 бүлгийн 404 сурагчид оролцсон. Мөн сарын 22-ны өдөр “Номын баяр” арга хэмжээг сумын Соёлын төвөөс зохион байгуулж, иргэд байгууллагууд ном хандивлалаа.

2017 оны 8 дугаар сарын 25-ны өдөр “Ахмадын өдөр”-ийг угтаж ахмадын тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн санхүүжилтийн талаарх мэдээлэл, шинээр батлагдсан “Ахмад настны тухай хууль”, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаарх мэдээллийг нийт 62 ахмадад хүргэлээ. Мөн “Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн хаалтын ажиллагаанд орон нутгийн иргэдийг оролцуулж, нутгийн шимт хөрсөнд ургасан хүнсний ногоо, даршилсан ногоо, зөгийн бал, цагаан идээгээр үзэсгэлэн худалдаанд оролцлоо.

Ерөө сум:

Сумын төвийн зам засварын ажлыг аймгийн эрх шилжсэн хөрөнгөөр “Сэлэнгэ АЗЗА” ХХК-ний зам засварын бригад энэ сарын 08-ны өдрөөс эхлэн гүйцэтгэж байна. Энэ ажилд “Болд Төмөр Ерөө гол” ХХК-ний 57,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, нийт 87,5 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдэж байна.

Мөн аймгийн хөрөнгөөр 1-р багийн 5-р хэсэгт Хүүхдийн тоглоомын талбай байгаа ба тоглоомын талбайд хашаа, сүүдрэвч, хүүхдийн тоглоом, сагсан бөмбөг, волейволын талбай, түрник суурилуулах ажлууд тус тус хийгдэж дууслаа.

Сумын хэмжээнд 2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үүднээс нийт 369 иргэнээс хадлан өвс бэлтгэх өргөдөл хүсэлтийг хүлээн авч 296 иргэнтэй 11851 га талбайд хадлангийн гэрээг байгуулан Могой, Өлөнт, Хонгорын нуруу, Ялбаг, Бөхлэйн хөндий зэрэг алслагдмал газарт 3180 га талбайд бизнесийн зориулалтаар 20 иргэнтэй гэрээ байгуулж сумын өвсний фондыг бүрдүүлж байна. Одоогийн байдлаар

сумын хэмжээнд 12200 тонн хадлан бэлтгээд байна. Сумын 1,2,3-р багийн малчин, мал бүхий өрхийн 21692 толгой бог мал угаалганд хамрагдсанаас гадна паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 6100 бог, 6000 бод малд ивомекийн боловсруулалтыг хийж, 7000 бог, 2265 бод малыг альбендозолоор туулгаж ариутгал халдваргүйжүүлэлтэнд 41 өвөлжөө, хашаа хороо, 10 агуулах зоорь, 2 уст цэг, 1 тэжээлийн ахуулах, 2 түүхий эд бэлтгэх газар, 5 мал амьтны тоног хэрэгсэл, 1 бэлчээрийн талбайг хамруулж, 1000 үхрийг боом өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамруулан 500 үхрийг Дуут хавдар өвчнөөс сэргийлэх тарилгад хамруулсан.

Төр төсвийн байгууллагын халаалт, дулаалгын ажлыг эрчимжүүлэх үүрэг даалгаварыг холбогдох байгууллагын дарга, аж ахуйн нэгжүүдэд өгч ажиллалаа.

Сумын хэмжээнд өнөөдрийн байдлаар 12 аж ахуйн нэгжийн 4996 га талбайгаас 7975 тонн үр тариа хураан авсан ба га-н дундаж 16цн, улсад одоогийн байдлаар 2042,5тонн үр тариа тушаагаад байна. Мөн төмс 18 га талбайгаас 216 тонныг хураан авч га-ын дундаж 120цн, хүнсний ногоо 46,2 га талбайгаас 613 тонныг хураан авсан ба га-ын дундаж 132 центрээр тогтоодлоо.

Сумын эрүүл мэндийн төв тайлант сард амбулаториор 285 хүнд үзлэг хийж, 0-15 насны хүүхдийн дархлаажуулалтын хамралтыг 100%-д хүргэж, тарилгат халдварт өвчин гаргалгүй ажиллаж байна. Жирэмсний хяналтанд 40 эх хяналтанд байгаа бөгөөд 9 сард шинээр 7 эхийг хяналтанд авсан. Яаралтай тусламжийн 33 нэрийн эм тарианы бэлэн байдлыг хангаж эмийн хадгалалт, хугцаанд хяналт тавьж үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг 90 %-д хүргэн ажиллаж байна. Мөн цэцэрлэгийн нийт 183 хүүхэд цагаан хорхойн шинжилгээ үзлэгт хамрагдахаас нийт 163 хүүхэд хамрагдсан бөгөөд 17 хүүхэд буюу 10.6 % цагаан хорхойтой гарсан. Эдгээр хүүхдийн эцэг эхэд зөвөлгөө өгч, эм уулгаж 7 хоногийн дараа давтан шинжилгээнд хамруулж эрүүлжүүлсэн.

Зүүнбүрэн сүм:

Сумын Засаг даргын 12 захирамж гарснаас цаг үеийн ажлыг шуурхай зохион байгуулах зорилгоор ажлын хэсэг байгуулсан 3, иргэний бүртгэлтэй холбоотой 2, газрын харилцааны асуудалтай холбоотой 4, мод бэлтгэх зөвшөөрөл олгох тухай 1, боловсон хүчний холбогдолтой 2 захирамж тус тус гарч хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Иргэний гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шинэ төрсөн 5, эцэг тогтоолт 3, овог нэр өөрчлөлт 2, үрчлэлт 1, нас баралтын 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 11, иргэний үнэмлэх гээгдүүлээд дахин авах 6, иргэний үнэмлэх олголтын 15, шилжин явсан 9, шилжин ирсэн 9 нийт 62 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлээ.

Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтэс, Хүнс хөдөө аж ахуйн газарт байгалийн хадлан тэжээл бэлтгэлийн мэдээг 7 хоног бүр мэдээлсэн бөгөөд сумын хэмжээнд байгалийн хадлан тэжээл бэлтгэл 3800 тн, сумын нөөц өвч 860 боодол буюу 21750 кг өвсийг бэлтгээд байна. Иргэдийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сумын хэмжээнд 560м³ түлшний мод олголоо.

Нийгмийн халамжийн сангаас жирэмсэн, нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 66 иргэнд 2.4 сая, халамжийн сангаас тэтгэвэр авагч 50 иргэнд 7.0 сая, асаргааны тэтгэмж авагч 26 иргэнд 1.8 сая, бүрэн хараагүй иргэний харилцаа холбооны зардал 6 иргэнд 80.000, онцгой тохиолдлын амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж авагч 19 иргэнд 1.1 сая нийт 13.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олголоо. Түлшний модны төлбөр хураамж 340,0, 1 иргэнд торгууль 150.0, нөхөн төлбөр 500.0, байгалийн ургамлын төлбөр хураамж 20 сая, жимсний төлбөр хураамж 245.0 төгрөгийг тус тус төрийн санд төвлөрүүлэн ажиллаа.

Тагнуулын Ерөнхий газрын Сэлэнгэ аймаг дахь газраас орон нутагт терроризмыг үл нутагшуулах, террорист этгээдийг үл орогнуулах, террорист этгээд, бүлэг үүсэхээс сэргийлэх, оролдлогыг таслан зогсоох, гэмтэнд ял оногдуулах мэдлэг, чадавхиа төгөлдөржүүлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор “Монгол Улсын

терроризмын дотоод нөхцөл байдал”, “Төрийн болон албаны нууцын тухай” хууль 2017 оны 09 дүгээр сарын 01-нээс хэрэгжих эхэлсэнтэй холбогдуулан “Төрийн болон албаны нууцын тухай хууль, төрийн болон албаны нууцын албан хэрэг хөтлөлт, мэдээлэл технологийн орчин дахь төрийн нууцын хадгалалт, хамгаалалтын талаархи сургалтуудыг зохион байгуулсан бөгөөд сумын Засаг даргын Тамгын газрын 17 төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг хамрууллаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх 22 дэх удаагийн арга хэмжээг энэ сарын 10-ны өдөр зохион байгуулж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас хилс хэрэгт хэлмэгдэгсдийн гэр бүл 3 иргэнд хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардууллаа.

“Боловсролын чанарын шинэчлэл төсөл”-ийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудын бага ангид нийлүүлэх STEM сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглахад дэмжлэг үзүүлэх зорилготой STEM боловсролыг бага ангийн сурагчдад эзэмшүүлэх арга зүй сургалтанд бага боловсролын сургалтын менежер, бага ангийн 2 багшийг хамрууллаа.

Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль, цэцэрлэгийн 2017-2018 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж 14-р цэцэрлэгт 158, Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуульд 459 сурагч хамрагдаж байна. Сумын ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн мэдээлэл зүйн кабинетад 15 ширхэг DELL маркийн I3 суурин компьютерыг хүлээн авлаа.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт 3 өрхийг нэмж хамруулан 21,0 сая төгрөгийн мал худалдан малжуулах арга хэмжээ авсан. Аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт хэлэлцээрийн талаар Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль, 14 дүгээр цэцэрлэг, Засаг даргын Тамгын газарт шалган зөвлөх үйлчилгээ үзүүлж, хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдтэй уулзаж зээлээ хугацаанд төлүүлэх талаар мэдэгдэл өгсөн.

Тайлант хугацаанд ажилгүйдлийн бүртгэлд 3, шинэ ажлын байранд 6 иргэнийг бүртгэж нийт шинэ ажлын байр 31 байна. Ахмад настныг дэмжих хөтөлбөрийн дагуу 1 иргэнд 2,5 сая төгрөгийн зээлийг олгож, ахмад мэргэжилтэний зөвлөх үйлчилгээг 6 ахмад настан үзүүлж, мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө өгөх үйлчилгээнд 20 иргэнийг хамрууллаа.

Сумын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд цэцэрлэгт 1941 хүүхэд, Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн бага бүлэгт 241, дунд бүлэгт 149, ахлах бүлэгт 69 сурагчийг хамрагдаж байна.

Сумын эрүүл мэндийн төвд 12 иргэнийг хэвтүүлэн эмчилж, амбулаториор 339 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 126, урьдчилан сэргийлэх үзлэгээр 154, диспансерийн хяналтаар 32, гэрийн идэвхтэй эргэлтээр 12, дуудлагаар 15 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүллээ. Мөн эх хүүхдийн хяналтыг тогтмол зохион байгуулж, ээлжит товлотт вакцинд 1 хүртэлх насны хүүхдүүдийг 100 хувь хамруулж, эх хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээл хөтөлбөрийн дагуу зорилтод бүлгийн 76 хүүхдэд олон найрлагат бичил тэжээлийн холимог олголоо. “Артерийн даралт болон чихрийн шижингийн үзлэгт 154 иргэнийг хамрууллаа.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон олон нийтийн түвшинд мобайл технологийг нэвтрүүлэх нь төсөлд 0-5 насны хамрагдвал зохих 410 хүүхдээс 415 хүүхэд хамруулж 101.3 хувь, 6-17 насны хамрагдвал зохих 642 хүүхдээс 448 хүүхэд хамруулж 69.7 хувь, 18-39 насны хамрагдвал зохих 988 иргэнээс 391 иргэн хамруулж 39.5 хувь, 40-64 насны хамрагдвал зохих 694 иргэнээс 393 иргэн хамруулж 56.6 хувь, 65 наснаас дээш хамрагдвал зохих 115 иргэнээс 93 иргэн хамруулж 80.8 хувь, зорилтод бүлгийн 405 иргэн хамруулхаас 381 иргэнийг тус тус программд шивж оруулаад байна.

Мандал сум:

Сумын хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилах, мэргэжлийн албадуудын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор энэ сарын 22-ны өдөр “Соёмбот” талбайд “нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгууллаа. Өдөрлөгт сум дундын шүүх, сум дундын прокурорын газар, онцгой байдлын хэлтэс оролцсон. Энэ үеэр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 3 сарын хугацаатай зарлагдсан “Гэмт хэрэг, зөрчилгүй хамт олон” аяны 1 дүгээр шатыг дүгнэж УБТЗ-ын барилга ашиглалт үйлчилгээний 1-р анги, “Спирт бал бурам” ХХКомпани, Дуу бүжгийн “Мөнгөн хараа” чуулга, Хэрх тосгоны захирагчийн албадыг өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж, аяны 2-р шатыг эхлүүлээ. Мөн 20 төрлийн санамж, сэрэмжлүүлэг 5200 ширхэгийг тарааж, холбогдох чиглэлээр үйлчилгээ үзүүлсэн.

Аймгийн хэмжээн дэхь 6 тосгодын туршлага солилцох нөхөрсөг уулзалтанд Хэрх, Рашаант, Дулаанхаан, Номгон, Бугант, Түнхэл зэрэг тосгодууд оролцож, тосгодод тулгамдаж буй асуудлууд сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, гарсан шийдвэрүүдийг дээд шатны байгууллагад уламжиллаа.

Сумын иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Баянхангайн 6-р багт байрлах хогийн төвлөрсөн цэгийг цэгцлэх, тархалтын талбайг багасгах ажлыг эхлүүлж, Ширхэнцэг хайрханы өвөрт байрлах цэцэрлэгт хүрээлэнд 40 ш гоёлын модон гэрэлтүүлэг суурилуулж хотын өнгө үзэмжийг нэмэгдүүллээ. Мөн Минжийн хангайн багт Нарангийн гудамжинд 24 цагийн турш ажиллагаатай анхны ухаалаг буюу автомат худгийн системийг суурилуулж, Түнхэл тосгонд баригдсан 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга байгууламжийг ашиглалтад оруулж, Түнхэл 5-р багийн ЕБС-д 12м х 2.35м хэмжээтэй, септик систем бүхий ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж барьж ашиглалтад оруулж, сургалтын таатай орчныг бүрдүүллээ.

“Ноён уулаа аварья” хөдөлгөөний тэргүүн О.Цэрэннадмидийн ирүүлсэн гомдол, мэдээлэлийн дагуу Хэрх 4-р багийн нутагт байрлах Арцатын аманд шалгалт хяналт шалгалтын ажил явуулж “Таван амт” гэх газраас хууль бусаар алт олборлоод буцаж явсан 2 иргэнийг саатуулан зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж тус бүрд 150,000 төгрөгийн торгууль ногдуулсан. Мөн мод бэлтгэлийн аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, хууль бус мод бэлтгэлийг зогсоох зорилгоор хяналт шалгалтын ажлыг тогтмол явуулж 5 машиныг саатуулан шалгаж 1 иргэнд 300,000 төгрөгийн торгууль ноогдуулсан. Тус сумын Хэрх 4-р багийн нутаг дэвсгэрт Дэрэвгэр жигэрүү гэх ургамал иргэд түүж бэлтгэж байна гэсэн дуудлагын хяналт шалгалтыг хийж, хууль бус арга хэмжээг таслан зогсоосон. Байгалийн ургамалыг сэргээн нутагшуулах, тарималжуулах, эмийн болон ашигт ургамал бэлтгэх, нөхөн сэргээх, байгалийн ургамалыг сэргээн нутагшуулах, тарималжуулах эрхтэй мэргэжлийн байгууллага “Ноён Ширхэнцэг” ХХК-тай 500 кг дэрвэгэр жиргэрүү бэлтгэх гэрээ байгуулан 5,0 сая төгрөгийг төрийн санд байршуулсан.

Орхон сум:

Тайлант хугацаанд сумын төр төсвийн байгууллагын менежерүүдийн ажил төрлийн мэдээ мэдээлэл солилцох, үүрэг чиглэл өгөх уулзалтыг 1 удаа, сумын ЗДТГ-ын төрийн албан хаагчдын ажил төрлийн яриаг 2 удаа зохион байгууллаа.

Иргэд олон нийтэд цаг үеийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэх үүднээс [Сэлэнгэ аймаг Орхон сум](#) сумын цахим хаяг болон [Orkhon Sum ZdtgSelengeFacebook](#) хаягаар цаг үеийн мэдээ мэдээллүүдийг хүргэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны 08-р сарын 30-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаас гарсан шийдвэр, аймгийн ЗДТГ-ын даргаас өгөгдсөн үүрэг чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахтай холбогдуулан “Зөв төлөвлөө, төгс гүйцэтгэе” уриатайгаар “Цэгцтэй алба-чадварлаг албан хаагч” 14 хоногийн аяныг зохион байгуулахаар 19 цогц арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ховор ургамал болох “Дэрэвгэр жиргэрүү”-г түүж бэлтгэх зөвшөөрлийг “Ноён ширхэнцэг” ХХК-нд олгосонтой холбоотойгоор сумын хэмжээнд 1 тн ургамлыг түүж бэлтгүүлэх гэрээг байгуулан байгалийн ургамал ашигласны төлбөрт 10,0 сая төгрөгийг орон нутгийн дансанд төвлөрүүлсэн. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрөлгүй ховор ургамал болох “Дэрэвгэр жиргэрүү”-г түүхийг завдсан Сайхан сумын харъяат 3 иргэнд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу тус бүрт нь 150000 төгрөгийн, нийт 450.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, 13 ширхэг үндэс түүдэг багажийг хураасан. Мөн тус сумын Шар хөтөлөөс зөвшөөрөлгүй тарвага агнахыг завдсан 1 иргэнд 150000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцсон. Мөн хууль бусаар 3 портер мод бэлтгэсэн Төв аймгийн Жаргалант сумын харъяат 3 иргэнийг Сайхан сум дахь цагдаагийн тасагт шилжүүлсэн.

2017 онд малын тэжээлийн зориулалтаар бэлтгэх хадлангийн тооцоог малын тоотой уялдуулан гаргасан өрх бүрийн хэрэгцээт өвсний хэмжээ, шаардагдах хадлангийн талбайн хуваарийг үндэслэн малчид газрын даамалтай хадлангийн гэрээ байгуулж, өнөөдрийн байдлаар 900 га талбайгаас 450 тн хадлан бэлтгээд байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, мал эрүүлжүүлэх арга хэмжээний хүрээнд бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг энэ сарын 04-ний өдрөөс 09-р сарын 20-ны хугацаанд тус сумын “Орхон сүрэг” ХХК 60 өрхийн 935 тугал, 55 өрхийн 5881 хурга 4207 ишиг, “Эгдэм” БГБХН 131 өрхийн 1210 тугал, 100 өрхийн 8510 хурга, 6110 ишиг нийт 2145 тугал, 14931 хурга 10317 ишиг технологит хугацаанд нь төлөвлөгөөний дагуу тарьж, Аймгийн Засаг даргын захирамж, аймгийн МХГ-аас ирүүлсэн албан тоотын дагуу мал, амьтны гоц халдварт шүлхий, цэцэг өвчний дэгдэлт улсын хэмжээнд зүүн болон төвийн бүсийн ихэнх аймгуудад гарч өвчний гаралт буурахгүй байгаа тул нийслэл болон бусад аймаг сумдаас амьд мал, амьтан худалдан авах, тээвэрлэх, тууварлах замаар өөрийн аймагт гаднаас мал, амьтан оруулж ирэх, мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг 2017 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн тодорхойгүй хугацаанд хориглосон тухай мэдэгдлийг малчин, мал бүхий иргэдэд дараан сэрэмжлүүлэг хүргэн ажиллаж байна.

2016-2017 оны хичээлийн жилд хүүхдийн сурч боловсрох таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 79,600,000 төгрөгийн хөрөнгөөр сургуулийн дээврийн засварын ажлыг хийснээс гадна сумын хөрөнгө оруулалтаар хичээлийн байрны гадна талбайг хайрган хучилттай болгож, БСШУСЯ, Дэлхийн банкнаас хамтран хэрэгжүүлж буй “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”-ийн 2 дахь шатны төсөлд хамрагдан “Оюуны хөгжлийн танхимтай боллоо. Мөн төслийн хүрээнд 6928434 төгрөгийн ухаалаг самбар, 4688400 төгрөгийн “STEM” сургалтын хэрэглэгдэхүүнийг аймгийн БСГ-аас нийлүүлсэн нь бага ангийн байгалийн ухаан, математик, технологийн хичээлийн агуулгыг нэгдмэл байдлаар сурагчдад олгож, бодит амьдралын асуудлыг шийдвэрлэх зохион бүтээх арга зүйд сургах боломжийг бүрдүүллээ. Мөн орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгжийн хандиваар 2 ангийн 30 ширээ, 60 сандлыг шинэчилж, 2 багшид Epson L360 принтер, Led зурагт, сургуулийн коридорт цэцгийн тавиурыг байршуулсан.

Сумын эрүүл мэндийн төвөөс эмчийн үзлэг 175 хийж, 5 төрлийн шинжилгээнд давхардсан 116 тоогоор хүн хамрагдсан. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд нийт 40-65 насны 613 иргэд бүртгэлд хамрагдсанаас, ЭМДаатгал төлсөн 315 иргэнийг В, С вирусын шинжилгээг авч, шинжилгээнд хамрагдсан иргэдээс 54 иргэн С вирус дахин тоологдож хариу ирсэн иргэдийг дээд шатлалын эмнэлэгт давтан шинжилгээнд хамруулан 3 иргэн эмийн эмчилгээнд хамрагдаж байна.

Сант сүм:

Сумын хэмжээнд үр тариа, тосны ургамал тариалсан нийт 4617 га талбайн 56,8% буюу 2624 га талбай ганд нэрвэгдэн хураах боломжгүй болсон байна. 448 га

талбай тэжээлд шилжиж, 33,2 % буюу 1535 га талбайгаас 1395,9 тн үр тариа хурааж авахаас тэжээлд шилжсэн 71 га талбайгаас 30 тн тэжээл бэлтгэсэн байна.

Мөн 210 га талбайд төмс тариалж 4,8% буюу 10 га талбай ургац алдаж, 138,1 га талбайд хүсний ногоо тариалж 8,6 % буюу 12 га талбай ургац алдсан байна. Төмс, хүнсний ногооны ургац хураалт эхэлж сумын хэмжээнд төмс 10 % буюу 20 га талбайгаас 310 тн, хүнсний ногоо 3,9% буюу 5 га талбайгаас 45 тн ургац тус тус хураан аваад байна.

Аймгийн Засаг даргын албан даалгавар, сумын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сумын Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/45 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд өвөлжилтийн бэлтгэл хангах албан даалгавар өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумын хэмжээнд 2 багийн 228 малчин өрх, 88 мал бүхий иргэн нийт 316 малтай өрхөд 83804 толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 170948 мал өвөлжүүлж хаваржуулна. Дээрх малыг өвөлжүүлж хаваржуулахад зориулан 6000 тн хадлан, 150 орчим тн хүчит тэжээл, 116 тн эрдэс тэжээл шаардлагатай байна.

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өвсний нөөц бүрдүүлэх тухай” тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бизнесийн хадлан хийх иргэдтэй гэрээ байгуулан нөөцийн өвсийг бүрдүүлэхээр /суманд шаардлагатай 80 тн/ бэлтгэл ажлыг хангаад байна.

Цэцэг өвчний тарилгад 43000 толгой мал хамрагдаж намрын тарилга туулгалтын ажлыг эхлүүлэхээр бруцеллезын вакцины татан авалт хийгдээд байна.

Малчид мал бүхий иргэд өвөлжөө хаваржаагаа засварлах ажил хийгдэж дууссан ба 42 өвөлжөө хаваржааны 13461м.кв талбайг ариутган халдваргүйжүүлсэн байна.

Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сумын дулааны эх үүсвэр халаалтын зуухны хэвийн ажиллах, цахилгаан шугам тоног төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагааг хангах талаар “Бүрэндулаан” ХХК-ы удирдлагуудтай уулзаж гэрээг шинэчлэх, ажлаа эрчимжүүлэх талаар мэдэгдэл өгсөн. Сумын хэмжээнд иргэдийн түлшний модны хэрэгцээг хангах ажил 80%-тай явагдаж байна.

Аймгийн болон сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын гүйцэтгэл 80 гаруй хувьтай байгаа ба гүний худаг болон төв усан сан, ус түгээх худгуудын засвар үйлчилгээг 3.800.000 төгрөгөөр хийж гүйцэтгэн нөөц усан санг ажилд оруулсан. Аймгийн замын сангийн /20 сая төгрөг/ хөрөнгө оруулалтаар Түргэний давааны зам засварын ажил бүрэн хийгдэж дууссан. БСШУСЯ-ны 34,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 13-р цэцэрлэгийн дулааны шугамын шинэчлэлийн ажил бүрэн хийгдэж нэмэлт 4,1 сая төгрөгийн санхүүжилтээр гал тогооны цахилгааны монтаж, анги танхимын хана таазны будаг, замаск болон цэвэр усны шугам засварлах ажил хийгдэж байна. Анги танхимаас бусад хэсгийн засварын ажил хийгдэж гүйцэтгэл 90%-тай явагдаж байна.

Орон нутгийн иргэдийн оролцоо дэмжлэгтэйгээр 13-р цэцэрлэгийн нэг бүлгийг 9,0 сая гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулж, 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна хашааг бүрэн сольж шинэчилсэн байна.

Сумын Эрүүл мэндийн төв Ивэн 1-р багийн хөдөөгийн иргэдийн дунд “Эмийн зохистой хэрэглээ” өдөрлөг зохион байгуулж 116 малчин, мал бүхий иргэд хамрагдсан байна. Өдөрлөгийн үеэр “Эмийн зохистой хэрэглээ”, “0-5 настай хүүхдийн асаргаа сувилгаа” сэдвээр сургалт мэдээлэл хийж зорилтот 40-64 насны иргэдийн дунд артерийн гипертензи, чихрийн шижин илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж БЖИ тодорхойлж, зөвлөгөө өгч ажилласан байна. Мөн “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээгээр эрүүл гарсан 50 иргэнийг В вирусын эсрэг дархлаажуулалтанд хамрууллаа.

Сант сумын түүхт 90-н жилийн ой 2018 онд болох бөгөөд түүхт ойгоо угтан сум орон нутаг, нутгийн зөвлөл, Сант сумтай ажил амьдралын холбоотой олон хүмүүс

сэтгэл зүтгэл гарган ажиллаж байна. Үүний нэг бол тус сумын өндөр настан н.Шагдаа гуайн гэр бүл, үр хүүхдүүд, н.Цэвээндаваа захиралтай "GO HELP" төрийн бус байгууллагын хамт олон, Сант сумын нутгийн зөвлөлөөс сумын Эрүүл мэндийн төвд иж бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн авто машиныг гардуулан өгч эрүүл мэндийн салбарт том хөрөнгө оруулалт хийсэн.

Цагааннуур сум:

2017 оны 09 дүгээр сарын 22-нд сумын төвийн хатуу хучилттай 1,3 км авто зам ашиглалтанд хүлээн авсан.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд малын бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 43610 төл малыг бүрэн хамруулж,

Суманд худалдаа үйлчилгээ, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, иргэдэд “Хөх сав, канистерийн хэрэглээ, хор хөнөөл” сэдэвт сургалт зохион байгуулж, хүнсний худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгчдэд “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”, “Хүнсний тухай хууль”-ийг хангаж ажиллах талаар мэдэгдэл хүргүүллээ.

Суманд Дэрвэгэр Жиргэрүү түүх зөвшөөрөлтэй 5-н аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус аж ахуйн нэгжүүдээс 45,0 сая төгрөгийг төрийн санд тушаасан.

Аймгаас авах санхүүгийн дэмжлэг төсвийн хуваарилалтаар 182588,4 мянган төгрөг буюу санхүүжилт 100 хувь ирсэн байна.Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хувьд санхүүжилт 100 хувь ирж цалин болон бусад зардлууд төрийн сангаар дамжуулан гүйлгээнүүд хийгдэж байна. Өссөн дүнгээр улсын төсөвт 35,914.60 мян.төг төвлөрүүлэхээс 121,418.00 мян.төг төвлөрүүлж 338%-ийн, аймгийн төсөвт 188,700.00 мян.төг төвлөрүүлэхээс 155,222.10 мян.төг төвлөрүүлж 82.3 %-ийн, орон нутгийн төсөвт 61,051.00 мян.төг төвлөрүүлэхээс 84,371.70 мян.төг төвлөрүүлж 138.2 %-ийн тус тус гүйцэтгэлтэй байна. Нийтдээ улс, аймаг, орон нутгийн төсөвт 285,665.60 мян.төг төвлөрүүлэхээс 361,011.80 мян.төг төвлөрүүлж 126.4 %-ийн гүйцэтгэлтэй байна.

Энэ сарын 14-16-ны өдрүүдэд аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас ажлын байр нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Бизнесээ эхэл” аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж, 20 гаруй иргэн хамрагдлаа.

Сумын хөдөлмөр эрхлэлтийн албанд 9 иргэн шинээр бүртгүүлсэн ба 9-р сарын 25-ны байдлаар ажил идэвхитэй хайж байгаа 42 иргэн байна.

Нийгмийн даатгалаас олгож буй тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд олголоо.

Баянгол сум:

Сумын хэмжээнд 9-р сарын 20-ны байдлаар ургац хураалт 24 хувьтай явагдаж байна. Үүнд улаан буудай 1884 га-аас 1420 тн, овъёос 60 га-аас 60 тн, рапс 37 га-аас 5 тн, төмс 35 га-аас 210 тн, хүнсний ногоо 67 га-аас 529 тн ургацыг тус тус хураан авсан мэдээтэй байна. Сумын малчид, мал бүхий иргэд 2100 тн сүрэл, 1520 тн байгалийн хадлан бэлтгэж, сумын өвс тэжээлийн аюулгүй нөөцөд 30 тн байгалийн хадлан бэлтгэсэн.

Улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт Шүлхий, Цэцэг өвчний дэгдэлт нэмэгдэж байгаатай холбогдуулан урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын захирамжаар шилжилт хөдөлгөөнийг тодорхойгүй хугацаагаар хориглож, олон улсын авто зам дагуу Цагдаагийн шалган нэвтрүүлэх постон дээр тээврийн хэрэгсэлд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж байна. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд адуунаас бусад бүх мал сүргийн төлд толгой дарааллан хамруулах ажлыг энэ сарын 5-ээс эхлэн 4 мал эмнэлэг, үржлийн нэгжүүд гүйцэтгэж 90 хувийн явцтай байна.

Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан “Ажлын байрны өдөрлөг” арга хэмжээнд 4 төр, төсвийн байгууллага, 2 аж ахуй нэгж, 18 иргэн 20 гаруй төрлийн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу ажил идэвхтэй хайгч иргэдээс зуучлах ажлыг зохион байгуулж 21 иргэнийг шинэ ажлын байранд, 3 иргэнийг сул чөлөөтэй ажлын байранд зуучилж нийт 24 иргэнийг байнгын, 17 иргэнийг түр ажлын байраар хангасан. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малжуулах арга хэмжээнд 6 малчин өрхийг хамруулж ХЭДС-аас 30.0 сая төгрөгийн мал худалдан авч малжуулсан. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээнд 6 ахмад мэргэжилтнийг хамруулж 1.6 сая төгрөгийн урамшуулалыг ХЭДС-аас олгосон.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2017-2018 оны хичээлийн нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, ЕБС нь нийт 404 суралцагчтай хичээллэж байна. Сумын улсын тэргүүний бүрэн дунд сургуулийн захиргаа, сумын удирдлагуудтай хамтран “Хүүхдийн төлөө хамтдаа” эцэг эхийн чуулганыг 2017 оны 09 сарын 03-ны өдөр амжилттай зохион байгуулж, нийт 317 эцэг эх оролцож сургуулийн чиглүүлэх хөтөлбөртэй танилцаж, багш, суралцагч, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулж ажиллах тал дээр санал бодлоо солилцсон.

Сумын эрүүл мэндийн төвөөс амбулаториор нийт 584 иргэнийг үзлэгт хамруулан, дээд шатлалын эмнэлэгт 22 иргэнийг онош тодруулахаар илгээж, 326 иргэнд өдрийн эмчилгээг эмчийн заалтаар хийж үйлчилсэн. Эх хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээл хөтөлбөрийн хүрээнд 0-5 насны 133 хүүхдийг жинлэн, товлолын дагуух дархлаажуулалтанд 100 % хамруулсан. Жирэмсний хяналтанд 43 эх байгаа бөгөөд энэ сард шинээр 5 эх хяналтанд орж, жирэмсний эрт үеийн хяналт 84%-тай байна. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд В,С вирусын халдвартай гэж оношлогдсон 197 иргэнээс 35 иргэний элэгний вирусын идэвхжилийг тоолуулснаас одоогийн байдлаар идэвхжил өндөр гарсан 8 иргэнийг вирус эсрэг эмийн эмчилгээнд хамруулсан.

Энэ сард шинэ төрсөн 16, шинээр гэр бүл болсон 1, эцэг тогтоолтын бүртгэл 8, үрчлүүлсэн 1, нас барсан 4, иргэний үнэмлэх олголт шинээр 16, дахин 11, сунгалт 20, шилжин ирсэн 23, шилжин явсан 14, иргэний бүртгэлийг тус тус хийсэн. Үл хөдлөхийн гэрчилгээ 1, газрын гэрчилгээ 11 иргэнд бүртгэлийн дэвтэр хөтлөн олгосон. Шинээр нөхөрлөл байгуулах 2 хуулийн нэрийн баталгаажилтыг хийлгэн улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Сайхан сум:

ДЗОУБ-н санхүүжилтээр “Онги Ээж” ХХК Жимстэй хорооллын усан хангамжийн худгийн усыг цэвэршүүлэх, халдваргүйжүүлэх, төмөргүйжүүлэх ажлыг /арван долоон сая төгрөг/ улсын стандартад нийцүүлж, усны хатуулаг 5,1 мг экв/л, 3 эквиваленттай төмрийн агууламж стандарт нормоос их болон нитритын бохирдол ихтэй байсан бол төхөөрөмж суурилуулсны дараа шинжилгээний дүнгээр усны ерөнхий хатуулаг 1.06 мг экв/л болж, илүүдэл төмөр арилж, ямар нэг бохирдолгүй цэвэр тунгалаг болсноор ундны усны эрүүл ахуйн стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

Монгол Улсын төмөр зам дайран өнгөрдөг нутаг дэвсгэр дээр амьдарч, үйл ажиллагаа явуулж байгаа ард иргэдийн амь нас эрүүл мэндийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Засаг Даргын Тамын газар болон Замын 6-р ангитай хамтран тус сумын Хөтөл Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн сурагч, 1-р багийн хөдөө амьдардагбага насны хүүхдүүд мөн төмөр замын дагуу амьдарч байгаа малчид, мал бүхий иргэдэд “Төмөр замын тээврийн тухай хууль”, “Төмөр замын Аюултай бүсийн дэглэм”-ийн тухай, Төмөр замын аюултай бүсээр нэвтрэн гарах журам, Зөрчлийн тухай хуулийн талаарх сургалт сурталчилгаа явуулж, гарын авлага, тараах материал бэлтгэж, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, сургалт

сурталчилгааны үеэр 100 гаруй тараах материал бэлтгэж, 1-р багийн хөдөөнөөс сургуульдаа явдаг бага, дунд ангийн 18 хүүхдэд сургалт зохион байгуулж, хөдөлгөөн ихээр байдаг Хөтөл Бэлэн далайн хоорондын 29 км-ийн 7-р зуутад байрлах хамгаалалтай гармаар нэвтэрч байгаа иргэдэд тараах материал болон Төмөр замын аюултай бүсээр нэвтрэн гарах журмын талаар мэдээлэл хүргэж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Залуусын өдөр"-ийг жил бүр тэмдэглэн өнгөрүүлж байх тухай заалт тусгагдсаны дагуу сумын залуусын нэгдмэл, хамтач байдлыг нэмэгдүүлэх зорилгоор энэ сарын 2-ны өдөр сумын төр төсөв, хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг залуусын төлөөлөл болох 85 залуу "Хараа голоо хамгаалъя" уриан дор нэгдэн, Дэлхийн Зөн ОУБ-ын ЗХОНХХ-ийн дэмжлэгтэйгээр Хараа голын эрэг дагуух амралт зугаалгын гол цэг болох 4 байршилд хогийн цэг барьж, голын эрэг дагуух хогийг цэвэрлэн, хамтдаа нөхөрлөж нэгэн өдрийг үр бүтээлтэй, орон нутгаа хайрлан хамгаалах итгэл, сэтгэлээр дүүрэн өнгөрүүллээ.

2017 оны 09-р сарын 01-ний өдөр хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаа Сайхан сумын 4 цэцэрлэг, 2 сургууль дээр болж, сумын удирдлагууд оролцон сурагч, багш нар болон эцэг эхчүүддээ баярын мэндчилгээ дэвшүүлсэн. Сумын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангид 229 хүүхэд элсэн орж, нийтдээ 1848 ерөнхий боловсролын сургуульд суралцаж, 4 цэцэрлэгт 1-5 насны 630 гаруй хүүхэд хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд Хөтөлийн ЕБС-ийн "Соёмбо" тасгийн хамт олон 2 өдрийн турш хүч чадал, авхаалж самбаагаа дайчлан амжилттай оролцож нийт Сэлэнгэ аймгийн 13 тасаг оролцсоноос Тэргүүн байр эзлэн, Аймгийн аврага тасгаар шалгарч шилжин явах цом, тугийн эзэд болж, Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон байна.

Залуу малчин, цөөн малтай иргэдэд мал маллагааны арга ажиллагааны болон аж ахуй эрхлэх ур чадвар олгох, малжуулах арга хэмжээг хэрэгжүүлж өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2 өрхийг нэмж хамруулж, иргэдийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ болон хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтанд хамруулж хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн, ажлын байранд дадлагажуулах замаар хөдөлмөрт бэлтгэх сургалтыг Ажилгүй, ажил хайгч иргэн, зорилтод өрхийн нийт 20 иргэнийг хамруулан сургалт зохион байгуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн асардаг эцэг, эхийг хамруулсан "Бизнесээ эхлэе, хөгжүүлэе" сэдэвт аж ахуй эрхлэлтийн сургалтыг 20 иргэнийг хамруулан зохион байгуулсан.

Ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох зорилгоор Ахмадын мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт 8 ахмадыг хамруулахаар материалыг бүрдүүлэн Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хүргүүлэн ажилласан.

2017 оны 09 сарын сумын орлогын төлөвлөгөө 120.99 хувиар биелсэн бөгөөд урсгал үйл ажиллагааны санхүүжилтыг 100 хувь олгосон. Зарим нэр төрлийн татварууд буюу үйл ажиллагааны орлогын татвар 79.4%, хөрөнгө борлуулсны албан татвар 97.24%, бууны албан татвар 33.92%, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласаны татвар 115.3%, улсын тэмдэгтийн хураамж 105.31%, хүү торгуулийн орлого 354.9 %, Байгалийн нөөц ашигласаны төлбөр 63.76%, бусад татвар 18.06% биелэлттэй байна. 9-р сарын төсвийн байгууллагуудын санхүүжилтийг төсвийн хуваарлалтын дагуу хийж нийт 161 ширхэг баримтаар 225 948 521,43 төгрөгийн гүйлгээг хийж гүйцэтгэлээ.

Энэ сарын 04-ны өдрөөс 13-ны өдрүүдэд сумын нийт 26,450 төл малд бруцеллёзын вакцинжуулалт, угаалга туулгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Байгаль Орчин Аялал Жуулчлалын яамнаас олгосон зөвшөөрлийн дагуу байгалийн ховор ургамал дэрвэгэр жиргэрүүг түүж бэлтгэх эрх авсан 2 аж ахуйн нэгжтэй дэрвэгэр жиргэрүүг түүж бэлтгэх гэрээ байгуулан сумын төрийн санд байгалийн нөөц ашигласаны төлбөр 15,0 сая төгрөгийг тушаасан байна.

Орхонтуул сүм:

Тайлант хугацаанд тус Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хангах зорилгоор дараах ажил арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажиллалаа.

Сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн явцыг оны эхний 8 сарын байдлаар салбар бүрээр сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хийгдээгүй байгаа зарим ажлуудын гүйцэтгэлийг 12 дугаар сарын 15-ны дотор хэрэгжүүлж дуусгах талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг холбогдох мэргэжилтнүүд, төсөв захирагч нарт үүрэг болголоо.

Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн Ажлын хэсэг томилох тухай А\117 тоот захирамж гарган зөвшөөрөлгүй барьсан өвөлжөө хашааг албадан буулгах ажлыг зохион байгуулж байна.

Зөвшөөрөлгүй өвөлжөө, хашаа барьсантай холбоотойгоор өвөлжөөтэй ойрхон хадлан хадсан, бэлчээр ашигласан гэсэн гомдол иргэдээс ирэх нь нэмэгдсэн тул Улсын байцаагчийн хугацаатай мэдэгдэл өгч мэдэгдлийн дагуу газраа чөлөөлөөгүй иргэдийн өвөлжөө хашааг албадан буулгах ажлыг эхлүүлээд байна.

Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх зорилгоор ЗДТГ-ын дарга, багийн дарга, ХАА-н тасгийн дарга, Татвар хураагч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг энэ сард татвараа төлөөгүй малчидтай уулзаж 46 иргэний бэлчээрийн төлбөрийг ногдуулж нийт 17,380,5 төгрөгийн дүнтэй мэдэгдэл хүргүүллээ.

Иргэдийг мэдээллээр хангах, шинээр хэрэгжиж байгаа хууль тогтоомжуудыг сурталчилах зорилгоор “Явуулын иргэний танхим” арга хэмжээг энэ сарын 22-ны өдөр зохион байгуулж Хонгор-Овоо 3-р багийн Баянцогтын ард намаржиж байгаа 30 гаруй өрхөд Зөрчлийн тухай хуулийн мэдээлэл өгч ажиллалаа. Мөн сумын ИТХ-аас батлагдсан Архигүй Орхонтуулчууд хөтөлбөр, Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, Өсвөр үе, хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчилах зорилгоор “Хүүхэддээ бахархан дуурайх аав, ээж нь байя” нэг сарын аян зохион байгуулагдаж байна. Энэхүү аяны хүрээнд

Хүүхдийн 108 утасны талаарх мэдээлэл, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн заавал мэдээлэх үүргийг сурталчилсан 2 ширхэг 1,50x200 метр хэмжээтэй хулдаасан самбарыг сумын төвийн төв зам дагуу байршууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тайлант сард Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн машин авах ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 09 дүгээр сарын 16-ны өдөр сумын Эрүүл мэндийн төвийн 80 жилийн ойн арга хэмжээн дээр тус байгууллагын хамт олонд хүлээлгэн өглөө.

Ахмадын баярыг угтан “Рашаант” амралтын газар 09 дүгээр сарын 23-ны өдөр ахмадуудаа хүлээн авч нэг өдрийн арга хэмжээ зохион байгуулан Засаг даргын нөөц хөрөнгөөс 100,000 төгрөг зарцуулсан байна. Ахмадын баярын хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.

Сумын ИТХ-аас баталсан “Соёлч өрх, орц” шалгаруулах журмын хэрэгжилтийг хангасан Шар-Усны 1-р багийн иргэн Д.Батжил, Д.Мөнгөн Баянцогт 2-р багийн иргэн

Ц.Оюунбат, Б.Баатархүү, Ц.Тулга, А.Отгонгалаа нарын өөрсдийн амьдарч байгаа орчин нөхцөлөө тохижуулсан байдалтай танилцаж, журмын болзол журмыг танилцууллаа.

Тайлант сард ирсэн бичиг-36 үүнээс хариутай 9 бичиг ирснээс хугацаандаа явсан бичиг-8, хугацаа болоогүй 1 бичиг ирсэн байна. Явсан бичиг-27 байна. Засаг даргын А захирамж-11, Б тушаал-1 гарсан байна. Иргэдээс нийт 18 өргөдөл хүсэлт ирсэнийг сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж хариуг албан тоотоор хүргүүлээ. Өргөдөл шийдвэрлэлт 100 хувьтай байна. Иргэдээс ирүүлсэн өргөдлийн дийлэнхи нь зөвшөөрөлгүй барьсан өвөлжөө хашаа албадан буулгахтай холбоотой асуудал эзэлж байна.

Энэ сард шинээр төрсөн-4, шилжиж ирсэн-5, шилжиж явсан-15 иргэ, нас баралт-4 бүртгэгдсэн байна.

Нийгмийн халамжийн сангийн 9-р сарын халамжийн тэтгэврийг 35 иргэд 5086670 төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 19 иргэнд 1520000 төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 16 эхэд-760000 төгрөг, алдар цолтны тусламжийг 4 иргэнд 650000 төгрөг тус тус олгосон байна. Халамжийн тэтгэвэрт шинээр 1 иргэн хамрууллаа. Алдарт эхийн одонгоор шагнагдсан 1 эхийн материал хүлээн авч тусламж, дагалдах мөнгө 120000 төгрөгийг олголоо.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн хүрээнд 2 ахмад настанд шүдний хөнгөлөлт 185000 төгрөг, рашаан сувилалд сувилуулсан 2 ахмад настанд 515000 төгрөгийн хөнгөлөлт үзүүллээ. Шинэ ажлын байр бий болгох зорилтын дагуу 18 ажлын байрны бүртгэл мэдээллийг хийж баталгаажуулан явууллаа. Мөн ажилд зуучлах үйлчилгээнд дээрх 18 иргэнийг зуучлан бүртгэл мэдээллийг хийж явуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2017-оны 6-р сарын 30-ны өдрийн 04 тоот албан даалгаварын дагуу малчид, мал бүхий иргэдийн 2017-2018 оны мал өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, өвс хадлан тэжээл бэлтгэх, хашаа хороогоо засварлах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж одоогийн байдлаар 3800 тн байгалийн хадлан, 1.2 тн гар тэжээл бэлтгээд байна. Мөн энэ өвөл өвөлжих малын тоог гаргаж шаардагдах бэлчээр, хадлангийн тооцоог хийж тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг үр тариа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд гэрээлэн ажиллаж байна.

Сумын хэмжээнд 9-р сарын 25-ны байдлаар ургац хураалт 85%-тай явагдаж, нийт 3999 га-ийн ургац хурааж 2387 тн улаан буудай, хүнсний ногоо 46,3 га-ийн ургацыг хурааж 374,4 тн-ыг, төмс 24,2 га-аас 246,8 тн-ыг хураан аваад байна.

2017 оны жилийн эцсээр тэмээ 416 адуу 13000 үхэр 18800 хонь 103400 ямаа 72000 толгой мал тоологдох тооцоо гарч үүнээс: 2017-2018 оны өвөл хаврын улиралд хонин толгойд шилжүүлсэнээр 378644 толгой малд 14600 мян/тн өвс 2860 мян/тн хүчит тэжээл шаардагдаж байна.

Оны эхний 9-н сарын байдлаар өссөн дүнгээр халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд Цэцэг өвчний вакцин 169223 хонинд, шөвөг яр 8500 толгой төлд, ДХХ-н эсрэг вакцин-2600 богт, гахайн мялзан 200 толгойд тус тус хийгдсэн байна. Мөн празитах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд үхэр 1850 толгойд, бол-15000 толгойд, бруцеллёзийн вакцинийг 18200 бодод, 5000 толгой бог малд хийсэн.

Мал сүргийг празитах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, Мал үржлийн нэгжүүдийн ажлын ачааллыг хөнгөвчилөх мал бүрийг аливаа халдварт болон празитах өвчнөөс сэргийлэх үүднээс иргэн, аж ахуй нэгжийн хандивар Малын угаалгын ванн, тарилгын хашаа хоёрыг барьж энэ сард ашиглалтанд орууллаа.

Баруунбүрэн сум:

Сумын хэмжээнд ургацын мэдээгээр үр тариа 5700 га талбайгаас 5964 тонн улаан буудай буюу нэгж га талбайгаас 10,4 цн, төмс, хүнсний ногооны хувьд төмс 80 га талбайгаас 640 тн, 554 тн хүнсний ногоо хураан аваад байна. Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг хангах, мал бүхий иргэдэд хадлангийн талбай хуваарилах ажлыг зохион байгуулж, нийт 157 өрхөд хадлангийн талбай хуваарилан хадлан бэлтгэх ажил хийгдэж байна. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг давхардсан тоогоор бүгд 201055 толгой мал амьтанд, паразиттах өвчнөөс эмчилэн сэргийлэх гуурын боловсруулалтанд нийт 58970 толгой мал амьтдыг тус тус хамруулсан. Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газраас өгсөн чиглэлийн дагуу малын гоц халдварт шүлхий, бог малын, мялзан, хонь ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг тандалтыг мал эмнэлэг, үржлийн нэгжүүдтэй хамтран малчин өрх бүрт тогтмол хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээр дамжин үүсэж болзошгүй өвчний эрсдлийн талаарх мэдээлэл, анхааруулга зөвлөмж, сэрэмжлүүлэгийг мэдээллийн самбарт байрлуулж, малчдад зөвлөгөө мэдээлэл өглөө.

Сумын ойн анги “Хэт Жолоо”ХХК-д Зүүвчийн аманд 9 га талбайд, “Нар Туг” ХХК Бумбатын аманд 9 га талбайд талбай тусгаарлалт хийж, аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Зөрчлийн тухай хуулийн сургалтанд 3 багийн байгаль хамгаалагч, Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, ойн тогтвортой менежемент нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд Дархан Уул аймгийн Шарын гол суманд зохион байгуулагдсан “Арчилгааны ажил” хийх сургалтанд Баруунбүрэн суманд үйл ажиллагаа явуулж буй “Бумбат хангай”, “Бүрэн Тоонч”, Бүрэн төгөл”, “Ногоон сан”, “Далт” зэрэг нөхөрлөлүүдийн ахлагч гишүүдтэй хамтран таван өдрийн онол болон дадлагын сургалтанд хамрагдлаа.

Сумын эрүүл мэндийн төвөөс амбулаторийн үзлэг 123, урьдчилан сэргийлэх үзлэг 636 хийж, дархлаажуулалтанд нийт 18 хүүхэд хамруулсан.

2017-2018 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын хүрээнд Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтын 15 сая төгрөгөөр сургуулийн биеийн тамирын заал, технологийн кабинет, номын сангийн цонхыг вакумжуулж, аймгийн 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургуулийн дотуур байрны их засварын ажлыг хийж, “Ивэн Түрүү” ХХК-наас шинээр орж буй 6 настнуудад зориулж нэг ангийн 15 ширхэг ширээ, 30 ширхэг сандлыг хандивлаж, дотуур байранд 3 ширхэг камер суурилуулсан.

Энэ хичээлийн жилд тус суманд СӨБ-д хамрагдах 2-6 насны хүүхэд 303 хүүхдээс өдрийн сургалтанд 160 хүүхэд, хувилбар сургалтанд 60 хүүхэд хамруулан 24 багш ажилчидтай ажиллаж байна.

Шаамар сум:

Сумын хэмжээнд ургац хураалтын мэдээгээр үр тариа 520 га-аас 400 тн, төмс 82 га-аас 830 тн, хүнсний ногоо 153.5 га-аас 1862.6 тн ургац хурааж, үр тариа 26,5 хувьш, төмс 91 хувь, төмс 91 хувь, хүнсний ногоо 78 хувьтай байна. Ургац хураалтын мэдээг 7 хоногт 2 удаа аймгийн ХХААГ-т өгч ажиллаа. Улаанбаатар хотын дүүргүүдэд гарсан үзэсгэлэн худалдаанд сумын иргэдийг оролцуулснаас гадна “Намрын ногоон өдрүүд 2017” арга хэмжээнд 12 зөгийчин, 18 ногоочин оролцож зөгийн бал, төмс хүнсний ногооны борлуулалт хийлээ. Мөн аймгийн төвд болсон ДЗМОУБ-ын Сэлэнгэ нутгийн хөгжлийн төслийн хаалтын арга хэмжээ үзэсгэлэн худалдаанд сумын 40 гаруй иргэний 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнтэй оролцлоо.

Сумын хэмжээнд 217 иргэн хадлан хадах талбай ашиглах гэрээ байгуулан бэлтгэж, сумын малын эмч, мал эмнэлэг үржлийн нэгжээс Дэлгэрхааны 1-р багийн 4 суурийн 475 хурга ишгэнд тарилга, 9 суурийн 1780 толгой бог малыг ванинд /угаалганд/ оруулж хээлтүүлэгч, Охиндий багийн 4 иргэний, Дэлгэрхаан багийн 5 иргэн, Дулаанхаан багийн 2 иргэний хадлангийн талбайн маргааныг шийдвэрлэлээ.

Аймгийн Тагнуулын газраас шинээр батлагдсан Төрийн албаны нууцын тухай хуулийн тухай, Терроризмын тухай сургалтыг зохион байгуулснаас гадна аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Ойн тухай хууль, Амьтны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Газрын тухай хууль зэрэг хуулийн хэрэгжилтийн хүрээнд эргүүл хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж сумын нутаг дэвсгэр Орхон голын гүүр орчимд Цагдаагийн алба хаагч болон Байгаль хамгаалагчийн хамт шөнийн эргүүлийг 21 удаа хийж, 110 гаруй иргэн, 51 тээврийн хэрэгсэл үзлэгт хамрагдан зөрчил дутагдалгүй тайван байв. Байгалийн ургамал буюу дэрэвгэр жиргэрүү зохих зөвшөөрөлгүйгээр түүхээр явж байсан 26 иргэнд хуулийн таниулга хийж буцаан явуулсан.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Прокурорын байгууллагын зүгээс хамтран зохион байгуулсан “Зөрчлийн тухай хууль”-ийн сургалтанд байгаль орчны байцаагч хамрагдсан. Мөн БОАЖЯ-наас байгалийн ургамал түүж бэлтгэх зөвшөөрөл авсан “Арвижих бизнес” ХХК, “Ардаян” ХХК гэх 2 компанитай Дэрэвгэр жиргэрүү түүх 2,5 тонн гэрээ байгуулан 25,000,000 төгрөгийн төлбөрийг төлүүлж зүй зохистой түүж бэлтгэх, хог хаягдал гаргахгүй байх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхаарууллаа.

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 9 сарын тайлан тэнцлээр 23 ажил олгогч, 196 даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэл төлж, сайн дурын даатгалд шинээр 3 хүн хамруулж нийт 168 даатгуулагчийн шимтгэлийг сар болон улирлаар төлүүлж, нийгмийн даатгалын дэвтэр болон эрүүл мэндийн даатгалын дэвтрийг тухай бүр нь баталгаажуулан ажиллаж байна.

Сумын 2017 оны Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт болон 2018 оны үндсэн чиглэлийн саналуудыг багцлан холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллалаа. Мөн Сумын Засаг даргын захирамжийн дагуу Дулаанхаан тосгоны эрхлэгчийн ажил хүлээлцэх ажлын хэсэгт орж ажиллалаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нарийвчилсан судалгаа болон ЕББДС-ын ХӨУЗ-ийн дэлгэрэнгүй судалгааг гарган аймгийн ГБХЗХ-ийн газарт цаг тухайд нь хүргүүлж ажиллалаа.

Халамжийн үйлчилгээнд хамрагдах 35 өргөдөл хүлээн авч холбогдох баримт бичгийг бүрдүүлэн дээд шатны байгууллагад уламжлан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид хамрууллаа.

"Хүнсний цаасан эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгох үйл ажиллагаанд хүнсний дэлгүүртэй хамтран ажиллах гэрээ"-ний дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн 6 өрхийн 33 гишүүнд 2017 оны 9 дүгээр сарын талон болох 46 ширхэг үнэт цаас бүхий 299000 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллага болох "Бүтээл сан" ХХК-ийн "Шонхлой" хүнсний дэлгүүртэй хамтран олгож олгосон тайланг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын “Дөл” тэмцээнд сургуулийн ахлах ангийн 11 сурагч амжилттай оролцлоо.

Хүдэр сум:

Сумын төр төсвийн байгууллагуудын ажиллагаа хэвийн явагдаж өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллав. Сумын Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж сум, орон нутгийн өвөлжилтийн бэлтгэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, явц үр дүнгийн тухай болон орон нутагт хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын зарим ажил арга хэмжээний талаар хэлэлцэн шийдвэрлээд байна.

Төсөвт байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулж “Хүдэр Дулаан” ХХК-ний ажилд хяналт тавьж дулааны шугамын шинэчлэлийн ажил бүрэн дууссан.

Иргэдийн хадлан, өвс тэжээлийн бэлтгэл 8-р сарын 20-ны байдлаар 8 аж ахуйн нэгж, 62 иргэнд нийт 3200 га газрыг олгосон бөгөөд, орон нутгийн малчид, мал бүхий иргэд хадлангийн ажлаа эхлэж одоогоор байдлаар ажлын явц 60 хувьтай, аж ахуйн нэгжүүд бизнесийн зорилгоор 1090 тн, малчид, мал бүхий иргэд 2080 тн өвс бэлтгэсэн байна. 9-р сарын 1-нээс 15 хүртэл “Марс Нуга” мал эмнэлэг, үржлийн нэгж бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг тугалд- 935, бог малд- 2720 тоо толгойд хийгдсэн.

Сумын хэмжээнд бороо их хэмжээгээр орсны улмаас ургац хураалтын ажил удааршилтай явагдаж байгаа боловч хүн хүч, техникийн хүчээр хураалтанд ороод сумын хэмжээн 240 га-гийн улаан буудай, 8 га-гийн төмс, хүнсний ногоо 28 га-г хураан аваад байна.

2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн соёлын төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажил хийгдэж, орон нутаг судлалын танхим, номын сан нээлтээ хийсэн. Мөн эрүүл мэндийн төвийн шалны засвар, сургуулийн дотуур байрны иж бүрэн засвар, сумын Засаг даргын Тамгын газар, соёлын төв, цэцэрлэгийн цэвэр ус, дулааны шугамын засвар, ахмадын байрны халаалт, сумын төвийн гэрэлтүүлэг, цамхагт гэрлийн ажил, жимсний цехийн 3,80 кв-тын шугам татах, дотор засварын ажил, сумын төвийн цэвэрлэх байгууламж барих, зам гүүр засварлах ажлуудын гүйцэтгэл 100 хувьтай, эрүүл мэндийн төвийн моорог, гражийн барилга, 23-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, сургуулийн гаднах биеийн тамирын талбай барих, 2-р багийн 7 худгийг хашаажуулах ажлуудын гүйцэтгэл 30-80 хувьтай хийгдэж байна.

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 24284.0 мянган төгрөг, гүйцэтгэл 42650,0 мянган төгрөг буюу 175 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба үүнээс орон нутгийн орлогын төлөвлөгөө 10920,0 төгрөгөөс гүйцэтгэл 4198,2 төгрөг, 38,4 хувь, аймгийн орлогын төлөвлөгөө 3505,0 төгрөг, гүйцэтгэл 33515,0 төгрөг буюу 95,6 хувьтай, улсын төсөвт оруулах орлогын төлөвлөгөө 2849,0, гүйцэтгэл 4936,8 буюу 173 хувийн биелэлтэй байна.

2017-2018 оны хичээлийн жилд ЕБС-ийн 22 бүлэгт 536 суралцагч, СӨБ-д 3-5 насны 186 хүүхэд хамрагдсан.

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг 72 иргэнд үзүүлсэн байна. Үүнээс 12 даатгуулагчид эрүүл мэндийн дэвтэр нээж, 32 даатгуулагчийн 1024.200 төгрөгийн шимтгэлийг эрүүл мэндийн даатгалын санд оруулж, 28 даатгуулагч улсын төсвөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлсөн байна. Сайн дурын даатгалд 1 даатгуулагч шинээр даатгуулсан. Нийт 42 даатгуулагчийн 1.366.400 төгрөгийг нийгмийн даатгалын санд оруулж нийгмийн даатгалын дэвтэр 6 даатгуулагчид шинээр нээж, албан журмын даатгуулагчдын эрүүл мэнд болон нийгмийн даатгалын дэвтрийг баталгаажууллаа.

Сүхбаатар сум:

Сумын Засаг даргын Тамгын газраас батлагдсан хуваарийн дагуу шуурхай хуралдааныг 4 удаа хийж, хуралдаанаас өгсөн нийт үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг цаг тухай бүр тооцож ажиллалаа.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын Ляонин мужийн Хайчин хотын захиргаанаас ирүүлсэн хамтран ажиллах саналын дагуу энэ сарын 21-23-ны өдрүүдэд сумын төлөөлөгчид ажлын айлчлал хийж, 2 хотын найрамдалд ах дүүгийн харилцааг эхлүүлж, худалдаа, эдийн засгийг хөгжүүлэх талаар санал солилцлоо.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас батлагдсан “Сүрьеэгүй Сэлэнгэ” аймгийн хөтөлбөр, сүрьеэгийн өвчлөлийн голомтын индексийг бууруулах, хүн амын дундах сүрьеэгийн талаарх мэдлэг хандлагыг дээшлүүлж, ялгаварлан гадуурхлыг үгүй болгох, сүрьеэгийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээг 90%, онош баталгаажилтыг 88%, эдгэрэлтийн түвшинг 90%-д хүргэж, нас баралтыг 2016 оны үзүүлэлтээс 10 хувиар бууруулах зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж, сумын хэмжээнд

8-н багийн нийт 360 иргэнийг тус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлтийг эрчимжүүлэх, өвчтөний эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэх, сүрьеэгийн өвчлөл тархалтыг бууруулах чиглэлээр судалгаа хийж давтан үнэлгээ хийлээ. Тус арга хэмжээг аймгийн Иргэний нийгмийн байгууллагын холбоо болон “МАСАМ” Олон Улсын байгууллага, багийн Засаг дарга нар, нийгмийн ажилтнууд хамтран зохион байгуулж, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэдийн дурсгалыг хүндэтгэх 80 дахь жилийн арга хэмжээг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тамгын газар хамтран хэлмэгдэгсдийн ар гэр, үр хүүхдийг оролцуулан зохион байгууллаа. Тус өдрийг угтаж “Улс төрийн хэлмэгдүүлэлтийн үр дагавар, сургамж” сэдэвт уулзалт хэлэлцүүлэг, дунд, ахлах ангийн сурагчдийн дунд “Мартах ёсгүй-Давтах ёсгүй” зохион бичлэгийн уралдаан, хүндэтгэлийн уулзалт хийж, партизаны талбайд алдрыг хүндэтгэн мод тарьж ногоон төгөлтэй боллоо.

Төсвийн төлөвлөгөөний дагуу аймгийн төсвөөс 269,734,300 төгрөгийн татаас авч орон нутгийн төсөвт байгууллагуудад 676,499,100 төгрөгийн санхүүжилт өгөх төлөвлөгөөтэйгээс 663,516,100 мянган төгрөг олгогдсон бөгөөд 9-р сарын өссөн дүнгээрсанхүүжилт 98.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

2017 оны орлогын гүйцэтгэлийг аймгийн Татварын албатай тооцоо нийлж баталгаажуулсан бөгөөд орон нутгийн орлогын гүйцэтгэл 8-р сарын гүйцэтгэлээр 134,6 хувьтай төвлөрсөн байна. Хүү торгуулийн орлого, үйл ажиллагааны орлого, улсын тэмдэгтийн хураамж зэрэг орлогууд 119 – 197 хувиар давж биелсэн ба бууны татвар 61,1 хувийн биелэлттэй хөрөнгө борлуулсны орлогын татвар 86,86 хувийн биелэлттэй байна.

Аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газартай хамтран байгууллагын албан хаагчдад шинээр батлагдан мөрдөгдөж байгаа “Хог хаягдлын тухай” хуулийг таниулан сурталчлах сургалт хийж, 38 албан хаагч оролцож эрх зүйн мэдлэгээ дээшлүүллээ. Мөн аймгийн Засаг даргын 2017 оны 09 сарын 13-ны өдрийн А/386 дугаартай “Насанд хүрээгүй хүнд ахуйн газ хэрэглээний хий /газ/ худалдан борлуулахыг хориглох тухай” захирамжийг сумын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг нийт 45 аж ахуйн нэгжид танилцуулж хэрэгжүүлэх талаар зөвлөгөө өгч, сумын ИТХ, ГХУСАЗЗөвлөл, сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран “Хамтарсан багийн чадавхижуулах нь” сэдэвт сургалт болж, 8 багийн хамтарсан багийн гишүүд, нийт 96 төлөөлөгч оролцсон.

Сумын хэмжээнд цэргийн албыг 2017 оны 2 дугаар ээлжээр хаах болон 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний шилжилт хөдөлгөөний мэдээг гарган аймгийн Цэргийн штабт хүргүүлсэн.

2017-2018 оны хичээлийн жилд сумын хэмжээнд Ерөнхий боловсролын 8 сургууль, насан туршийн боловсрол төвд нийт 4362 хүүхэд суралцаж, СӨБ-ын 8 цэцэрлэгт 1954 хүүхэд хүмүүжиж байна. Сургууль цэцэрлэгт мэргэжлийн багш бүрэн хангагдсан байна. Хичээлийн шинэ чилийн болон өвөлжилтийн бэлтгэл ажил хангагдсан, урсгал засвар бүх сургууль цэцэрлэгт хийгдэж дууссан, сантехник, цахилгаан хангамж хэвийн ажиллагаатай, ердийн галлагаатай 1,7-р цэцэрлэг, 5,6-р сургууль түлээ нүүрсний хангамжийг 30-45 хоногийн нөөцтэй байна.

Аймгийн Засаг даргын нэрэмжит Цэрэг спортын цогцолбор “Дөл” тэмцээнд сумын Ерөнхий боловсролын 5 сургуулийн 60 гаруй сурагчид оролцож, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль 2-р байранд шалгарсан.

Монголын ахмадын баярыг угтан Аймгийн ахмадын хороо, Сүхбаатар сумын ИТХ, сумын ЗДТГазархамтран ахмадуудын дунд “Спорт явган аялал”, “Хийн дасгал”, “Отог засах”, “АХА”, “Буухиа”, “Софт волейбол”, “Дуулах өдөр дуун цэнгүүн”, “Нийтийн бүжиг” зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.

ХХААХҮЯ-наас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээ энэ сарын 9-25-ны өдрүүдэд Улаанбаатар хотын

“Мишээл экспо” төвд зохион байгуулагдсан бөгөөд уг арга хэмжээнд тус сумын 1 аж ахуйн нэгж, 16 ногоочин өөрсдийн тарьж ургуулсан төмс хүнсний ногоо, даршилж нөөшилсөн бүтээгдэхүүн, мод бутны үр үрсэлгээгээ худалдан борлуулж 22,5 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Сумын хэмжээнд ургац хураалтын ажил 95 хувьтай явагдаж байгаа ба төмс 65 га-аас 1170 тн, хүнсний ногоо 42,1 га-аас 842,3 тн-ыг тус тус хураан авсан нь өнгөрсөн жилтэй харьцуулахад 0,3 хувиар өссөн дүнтэй байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд малчид мал бүхий иргэдэд өвөлжилтэнд бэлтгэх зөвлөмж гарын авлагыг тараан, одоогийн байдлаар малчид 3500 тн байгалийн хадлан, 11 тн тэжээлийг бэлтгэн авсан мэдээтэй байна.

Сүхбаатар сумын 8 багийн хэмжээнд “Эко өрх”-ийг сонгон шалгаруулах уралдааныг зарлаж Баянхан 4-р баг, Боргүвээ 5-р баг, Салхит 3-р баг, Буурхээр 8-р багийн 4 өрхийг “ЭКО ӨРХ”-өөр батламжлахаар боллоо.

Сүхбаатар сумын иргэдэд Алтанбулаг сумаас түлшний мод олгох ажил эхлэж одоогийн байдлаар 70 өрх 280 м³ түлшний мод бэлтгэн авсан. Мөн 20 иргэнийг түр ажлын байраар хангах төсөлд хамруулан “Тужийн нарс”-ны БЦГХЗ-аас түлшний мод олгосон байна.

2017 оны эхний 9 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэн 427 байсан бол 157 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 95 ажлын байранд 75 иргэн ажилд зуучлагдан, идэвхгүйн улмаас 109 иргэн хасагдаж, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 318 болсон байна. 2017 онд шинээр 190 ажлын байр бий болгохоос, 9 дүгээр сарын байдлаар 117 ажлын байр шинээр бий болж 61,5 хувийн биелэлттэй байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд нийт 25 иргэнийг хамрууллаа.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих жижиг зээлийг “Голомт банк”-аар дамжуулан олгохоор 9 иргэний материалыг хүргүүлэн 14 иргэн аж ахуй нэгжид 153,000,000 төгрөгийн зээл олгож, шинээр 13 ажлын байр бий болгож бүртгэж мэдээллээ.

Сумын Засаг даргын батласан удирдамжийн дагуу Сум хөгжүүлэх сангийн хөнгөлттэй зээлэнд хамрагдсан иргэдийн зээлийн үйл ажиллагаа, ашиглалттай танилцах, зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих, дүгнэлт өгөх, эргэн төлөлтийг төвлөрүүлэх зорилгоор хугацаа дууссан 8 багийн 39 иргэнд хугацаатай мэдэгдэл өгч, зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлогын төвлөрүүлэлт 97,648,097 төгрөг буюу нийт санхүүжилтийн 10,8 хувийн биелэлттэй байна.

Сүхбаатар сумын Тохижилт үйлчигээний газар нь иргэдэд “Тохижилт үйлчилгээ Сэлэнгэ Сүхбаатар” facebook хаяг болон “Сүхбаатар хотын ТҮГ” page хуудас хаягаар өөрсдийн өдөр тутмын үйл ажиллагаа болон багуудад ажиллах цагийн хуваарийг тухай бүр сумын ард иргэдэд тогтмол мэдээлэл өгч ажиллалаа.

Энэ 9 сарын байдлаар зам талбайн 9 үйлчлэгч өдөр бүр хариуцсан зам талбайн хог хаягдал цэвэрлэх авто замын нуухны шороог авах ажлыг тухай бүр хийж rolandмаркийн бункертэй нэг машин, ЗИЛ-130 машин 4, аймгийн Байгаль орчны газраас зарласан тендерийн дагуу “TOTAL импекс”ХХКомпаниаснийлүүлсэн “ISUZU ELF” өөрөө шахагч нэг машин нийт 6 машинаар аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийн хог хаягдлыг ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэн ажиллалаа.

Жавхлант сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус хуралдаан болж орон нутгийн өвөлжилтийн бэлтгэл ажлын талаарх мэдээлэл, сумын 40 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулсан тухай мэдээллийг сонож, зарим татвар, төлбөрийн хэмжээ тогтоох асуудлыг хэлэлцлээ.

Сумын Засаг даргын Тамгын газраас улирал бүр зохион байгуулдаг иргэдийн санал хүсэлтийг сонсох ажлыг зохион байгуулсан.

Малчдын хадлан тэжээл бэлтгэх газрыг хуваарилан олгож, ойн цэвэрлэгээний журмаар 41 өрх айл 180 м3 түлээний мод бэлтгэх гоожинг олгосон.

2017-2018 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

Сумын эрүүл мэндийн төвөөс тайлант сард нийт 275 үзлэг хийгдэж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж зөвлөгөө өгч, 20 иргэн хэвтэн эмчлүүлсэн. Товлолт дархлаажуулалтанд 25 хүүхдийг хамруулж, сумын хэмжээнд элэгний В, С вирусын илрүүлэг шинжилгээнд 40-65 насны 561 хүн хамрагдахаас 456 хүн хамрагдаж, С вирус илэрсэн 30 хүнийг эмчилгээнд хамраалж эхлээд байна.

Тайлант шинээр төрсөн 5, эцэг тогтоох 2, гэрлэлтээ бүртгүүлсэн 2, иргэний үнэмлэх олголт 17, иргэний үнэмлэх гээгдүүлсэн 3, үндэсний энгийн гадаад паспорт шинээр захиалах, хугацааны сунгалт хийх 2, шилжин ирсэн 2, шилжин явсан 6, шинээр иргэний үнэмлэх захиалсан 8, нийт 47 иргэний материалыг улсын бүртгэлийн санд шивж үйлчилгээ үзүүлсэн.

Ээлжит хуваарийн дагуу Мандал сумын ахмадын сувилалд 4 ахмад настанг сувилуулж, дотоодын рашаан сувилалд амарсан 6 ахмад настан, 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөнгөлөлт олгож, тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тавьж олгосон.

Түшиг сум:

2017-2018 оны хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагааг 09 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагааны хүрээнд 1 дүгээр ангид элсэн орж буй 46 сурагчдад сурах бичгийг үнэ төлбөргүй олгож, “Эх хэлний өдөр”-ийн хүрээнд 1-12 дугаар ангийн сурагчдад эх хэлний хичээлээр анги удирдсан багш нар сургалт явууллаа.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг хэлэлцүүлгийг зохион байгуулан ажиллаж, нийт 35 иргэний саналын хуудсыг аймгийн ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.

Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулж, төр төсвийн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцлаа. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хадлан тэжээл бэлтгэл 85%-тай, төмс хүнсний ногооны хураалт дууслаа.

Малчин, мал бүхий иргэдийн хадлангийн талбайг Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэн тогтоож, давхардсан тоогоор 195 малчин мал бүхий нийт 7,9 мянган га-аас 4000 тн хадлан бэлтгэж, Ганцын даваа, Моностой зэрэг газруудыг нөөцийн хадлан бэлтгэх газраар тогтоож, Шинэбадрах ХХК 20 га, орон нутгийн 2 иргэн тус бүр 5 га талбайд хадлан бэлтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд орон нутгийн аюулгүй нөөцөд 3000 боодол өвс нийлүүлэхээр шийдвэрлэгдэж, Бооцын тариа ХХК-ний үрийн агуулахад сумын өвсний нөөцийг бүрдүүлж эхлүүлээд байна. Мөн бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар 4 цэгээс үнэлж бэлчээрийн хадлан га талбайгаас 1243-1420 кг, бэлчээрийн даац 100 га талбайд хонин толгойд шилжүүлснээр 73-83 толгой ногдож байгаа нь бэлчээрийн даац оны эцэст тоологдсон 50,2 мянган толгой малд хүрэлцээтэй байна.

Төр, төсвийн байгууллагуудын тушаал, шийдвэр, архив албан хэрэг хөтлөлтөд үзлэг шалгалт явуулах ажлын хэсгийн байгуулан, ЕББДСургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв зэрэг байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн байдалтай танилцаж, заавар зөвлөмж хүргүүллээ.

Монгол Улсын Төрийн нууцын тухай хуулийн хүрээнд “Төрийн нууцыг хадгалж хамгаалах дотоод журам”-ыг боловсруулан батлуулж, төрийн нууцтай танилцах эрх бүхий 5 албан тушаалтнаас “Нууцын баталгаа” гаргуулж, лац тэмдгээр хангалаа.

Аймгийн болон сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажилд хяналтыг тавьж, өнөөдрийн байдлаар нийт 68,0 сая төгрөгний 11 ажил арга хэмжээнээс 43,5 сая төгрөгний 7 ажил арга хэмжээг хүлээн авч байнгын

ашиглалтанд хүлээлгэн өгөөд байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 11050,0 сая төгрөгөөр “Зөгий” хөтөлбөрийг хэрэгжүүлэн 3 өрхийг 17 бүл зөгийгөөр хангаж, энэ жил 6,0 сая төгрөгийн бал болон дайвар бүтээгдэхүүн борлууллаа. Сумын мал эмнэлэг, үржлийн нэгжид 5,0 сая төгрөгөөр мах, сүү, өндөг, зөгийн бал болон бусад хүнсний бүтээгдэхүүн шинжлэх бичил лабораторийн тоног төхөөрөмжийн худалдан авч олголоо.

Сум хөгжүүлэх санд 15,5 сая төгрөгийн эргэн төлөлтийг төвлөрүүлж, зээлийн хугацаа хэтэрсэн иргэдэд албан мэдэгдэл хүргүүллээ.

2017 оны 09 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд золбин нохой устгах ажлыг зохион байгуулж нийт 18 нохойг устгалаа.

Орон нутгийн орлого 101,948,9 мян төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 95101,7 мян төгрөг 57,9%-ийн биелэлттэй байна

Шинээр газар өмчлөх хүсэлтэй 9, хуучин хашааны газраа өмчлөх хүсэлтэй 2 иргэний өргөдлийг шийдвэрлэж, 4 өргөдлийг шийдвэрлэн, 3 иргэнд хариу хүргүүллээ. Тайлант хугацаанд 10 иргэнд 35 га буюу 2800,0 мян төгрөгний гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг үнэ төлбөргүйгээр өмчлүүлж, өвөлжөө хаваржааны зориулалтаар 3 иргэнд 2,34 га газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүллээ. Кадастрийн эрх бүхий “Хас маркет” ХХК-д хүсэлт хүргүүлэн 18 айл өрхийн хашааны газрыг кадастарт оруулж бүртгэлээ.

Ноосны урамшуулалд хамрагдах иргэдийн нэрсийг гарган 86 өрхийн 22610 кг ноосны материалыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүллээ. Бруцеллээс өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх ажлын хэсгийн байгуулан 2017 оны 08 дугаар сарын 30-аас 09 дүгээр сарын 20 буюу технологит хугацаанд хийж дууслаа. Халдварт паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг мал бүхий иргэдийн 68 өвөлжөө буюу 33470 м.кв талбайд ариутгал хийж 33546 толгой хурга ишгэнд туулгалт, угаалгыг 33627 толгой бог малд хийлээ. Мөн “Ариун таван хан” ХХК-тай хамтран төр, төсвийн байгууллагуудад хортон шавьж усгалын ажлыг гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд шинээр төрсөн 2, шинээр гэр бүл болсон 2, эцэг тогтоолт 1, нас баралт 1, иргэний үнэмлэх олголт 8, иргэний үнэмлэхний сунгалт 5, дахин олголт 4, шилжин явсан 4, шилжин ирсэн 6 бүртгэгдсэн бөгөөд иргэдийн шилжилт хөдөлгөөн энэ сард эерэг хандлагатай байна.

Хушаат сум

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаарх хэлэлцүүлгийг явуулж нийт 130 иргэнээс санал асуулгыг авч холбогдох газарт хүргүүлж, шинээр хэрэгжиж буй Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 5-р бүлгийн нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил бүлгээр гарын авлага бэлтгэн иргэдэд түгээж хуулиа сурталчилж байна.

Сумын хэмжээнд 9-р сарын 25-ны байдлаар үр тариа 7651 га-гаас 13772,0 тн, рапс 170 га-гаас 270.0 тн, төмс 127 га-гаас 1980.0 тн, хүнсний ногоо 126 га-гаас 1240.0 тн, хадлан 5450,0 тн-ыг хураан аваад байна.

Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд бруцеллез өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 2 багийн малчин, мал бүхий өрхүүдийн төл малыг хамруулж, шүлхий, цэцэг өвчний урьдчилан сэргийлэх тандалтыг хийж малчдыг гарын авлагаар хангаж, малын эрүүл мэндийн дэвтэр хөтлөлтийг шалган, малчин өрхүүдийн малаас түүвэрчилсэн цус авч бруцеллээс, лейкоз өвчний тандалт хийж байна.

“Мерси кор” ОУБ-аас хэрэгжүүлж буй “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” төсөлд тус сумын “Хушаатын баялаг” хоршоо сонгогдон ажиллаж сумын малд үзлэг ангилалтын ажлыг хийж байна. Ангилалтанд 4868 мал хамрагдсанаас үхэр 1226 үүний дотор хээлтэгч 1162, бух 64 хамрагдан 7 бух заазлагдан 57 бух үржлийн шаардлага ханган 216 хээлтэгчийг цөм сүрэгт бүртгэсэн байна. Нийт 3642 бог мал ангилалтанд хамрагдан 658 эм хонь 345 эм ямааг цөм

сүрэгт бүртгэн баяд хуц бойжуулах боломжтой 5 өрх, өлгийн улаан ухна бойжуулах боломжтой өрхөөр 4 өрхийг сонгосон байна. Мөн сумын бренд казакийн цагаан толгойт үүлдрийн үхрийн ашиг шимийг сайжруулахаар хамран ажиллаж байна.

Тайлант сард Татварын орлогын төлөвлөгөө 8831.0 сая төгрөг төлөвлөгдснөөс гүйцэтгэл нь 22613.1 буюу 256 хувийн биелэлттэй ажиллаж, галт зэвсгийн тооллого явуулж буутай иргэдийн шилжилт хөдөлгөөн хийж татварын баазыг цэгцлэн хувийн хэргийн баяжилт хийлээ.

Нийгмийн даатгалын шимтгэлд 31 байгууллага аж ахуйн нэгжийн 178885,9 мянган төгрөгний, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 108 хүний 20444,9 мянган төгрөгний шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 178 хүний 10200.0 мянган төгрөгний хураамжийг тус тус оруулаад байна. Шинээр тэтгэвэр тогтоолгох 17 хүний, шилжин ирсэн 1 хүний материалыг бодож баталгаажуулан тэтгэвэр тогтоолгох талаар зөвлөгөөг 22 хүнд, сайн дураар даатгуулах зөвлөгөөг 628 хүнд өгч үйлчилсэн байна.

Сумын эрүүл мэндийн төвөөс нийт үзлэгийн тоо 186 байгаа ба үүнээс амбулатори 155, урьдчилан сэргийлэх үзлэг 20, идэвхитэй хяналт 15, гэрийн идэвхитэй үзлэг 55 байна. Түргэн тусламжийн дуудлага 35 байгаа ба үүнээс алсын дуудлага 8 Хяналтанд байгаа жирэмсэн эх 13, 0-5 настай жинэлсэн хүүхэд 130, артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 2, чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт 2, урьдчилан сэргийлэх тарилгад 26 хүүхэд, шинжилгээнд 5 хүн хамрагдаад байна.

Сумын хэмжээнд “Залуучуудын хөгжил-2017” сэдэвт судалгааны асуулгыг төрийн болон хувийн хэвшлийн, ажилгүй залуучуудын төлөөллөөс авч аймгийн Хүүхэд гэр бүл, хөгжлийн газарт хүргүүлж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 6 иргэнд, бүлгийн зөвлөгөөг 34 иргэнд өгч, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил олгогч байгууллага иргэнээс сул чөлөөтэй ажлын байрны захиалга авч бүртгэн байнгын ажлын байранд 4 иргэнийг зуучиллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг “Хөдөлмөрт бэлтгэх, ур чадвар олгох” хөтөлбөрийн хүрээнд Монголын эрхлэлтийн бизнесийг дэмжих холбоотой хамтран Аж ахуй эрхлэлтийн сургалтанд 14 иргэнийг хамруулж “Чадамжийн гэрчилгээ” олголоо.

2017-2018 оны хичээлийн жилийн нээлтийн арга хэмжээг амжилттай зохион байгуулж, хүүхдийн байгууллагын эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах үүднээс нийт багш ажилчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулж, сургуулийн дээврийн засвар, гадна хашаа, биеийн тамирын зал мэдээлэл зүйн кабинетыг засварлалаа.

Энэ сард сумын хэмжээнд төрөлт 5, шилжин явсны 8, шилжин ирснийг 8, нас барсны 1, цахим үнэмлэх дахин авах 4, биеийн давхцахгүй өгөгдлийн 14, иргэний үнэмлэх олголтын 11 нийт 51 бүртгэл хийж 7 гэрчилгээ олголоо.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР